



Хүн амьтны
орон сууцны
ахуйн нөхцөл
боловсролын
бичигүсгийн
мэдлэгийн
хэрэглэгч:
тоо, бүтэц

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ
2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО

ГАР УТАС, ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧ: ТОО, БҮТЭЦ



Сэдэвчилсэн судалгаа

8



МОНГОЛ УЛСЫН
УНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО

ГАР УТАС, ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧ:
ТОО, БҮТЭЦ

Улаанбаатар хот
2011 он

DDC
004.678'021'517
И-733

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,
Засгийн газрын III байр
<http://www.nso.mn>
И-мэйл: nso@magicnet.mn

Сэдэвчилсэн судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж
боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

Энэхүү судалгаа нь англи хэл дээр хэвлэгдэж, хэрэглэгчдийн хүртээл болно.



ISBN 978-99929-64-69-3

АГУУЛГА

| | |
|---|-----------|
| Агуулга | 3 |
| Тайлан бичихэд оролцогчид..... | 4 |
| Товчилсон үгийн тайлбар | 8 |
| Өмнөх үг..... | 9 |
| | |
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ | 11 |
| 1.1 Оршил | 12 |
| 1.2 Судалгааны зорилго..... | 13 |
| 1.3 Судалгааны аргачлал, агууламж | 13 |
| 1.4 Ойлголт, тодорхойлолт | 13 |
| | |
| ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАР УТАС, ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ..... | 15 |
| 2.1 Нас, хүйсийн ялгаатай байдал | 20 |
| 2.2 Байршил, тархалт, хот, хөдөөгийн ялгаатай байдал | 24 |
| 2.3 Боловсролын төвшин | 29 |
| 2.4 Гэр бүлийн байдал | 32 |
| 2.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний гар утасны хэрэглээ | 34 |
| 2.6 Гадаадын харьяат иргэний гар утас, интернетийн хэрэглээ | 37 |
| | |
| ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ БА ӨРХИЙН ГАР УТАС, ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ..... | 39 |
| 3.1 Эдийн засгийн идэвх, ажил эрхлэлт | 40 |
| 3.2 Өрхийн интернет, гар утасны хэрэглээ..... | 48 |
| 3.3 Орон сууцны ялгаатай байдал | 51 |
| | |
| ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХАМААРЛЫН ШИНЖИЛГЭЭ..... | 55 |
| 4.1 Гар утас хэрэглэх төвшинд нөлөөлөх хүчин зүйлс | 56 |
| 4.2 Интернет хэрэглэх төвшинд нөлөөлөх хүчин зүйлс | 56 |
| 4.3 Гар утас, интернетийн хэрэглээний хоорондын хамаарал | 57 |
| | |
| ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ | 59 |
| ХАВСРАЛТ | 63 |
| Тооллогын асуулгын хуудас..... | 78 |



СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГААГ БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

НЭГ. ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН

Гэнэнгийн Элдэв-Очир

Математикийн багш, Эдийн засагч-Статистикч, Эдийн засгийн ухааны доктор, профессор
Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүн, зөвлөх багш

Төмөртолгойн Навч

Статистикч-Хүн ам зүйч, Эдийн засгийн ухааны магистр
Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүн, зөвлөх багш

ХОЁР. БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

Дагвадоржийн Даваасүрэн

Эдийн засагч-Хүн ам зүйч
Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэгийн судлаач

Сүрэнбаатарын Мөнхтулга

Эдийн засагч-Хүн ам зүйч
Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэгийн судлаач

ГУРАВ. ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

Цэндjavын Бадрах

Эдийн засагч
ҮСХ-ны MNG4P103 төслийн зөвлөх

Жигжидсүрэнгийн Ядамсүрэн

Санхүү-Эдийн засагч
Эдийн засгийн ухааны доктор, профессор

ДӨРӨВ. ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг

Хүн ам зүйн ухааны магистр
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны ажилтан

Баатарын Бадрал

Программ хангамжийн инженер
ҮСХ-ны Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын ажилтан

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | | |
|--------------|---|----|
| Хүснэгт 2.1. | Гар утас, интернетийг хоёуланг нь хэрэглэдэг болон хэрэглэдэггүй хүн амын тоо, гэр булийн байдаа..... | 33 |
| Хүснэгт 3.5. | Нийт өрхөд гар утасгүй өрхийн эзлэх хувь, аймаг, нийслэл, байршилаар | 48 |
| Хүснэгт 3.6. | Зургаа, түүнээс дээш насны хүн амд гар утас хэрэглэгчийн эзлэх хувь, орон сууцны төрлөөр...51 | |
| Хүснэгт 3.7. | Интернет хэрэглэдэг хүний тоо, хэрэглэдэг хэлбэр, орон сууцны төрөл, дунд эзлэх хувиар | 53 |

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

| | | |
|-------------|---|----|
| Зураг 2.1. | Гар утас, интернетийн хэрэглээг тодорхойлох асуулт, хариултын бүдүүвч..... | 16 |
| Зураг 2.2. | Зургаа, түүнээс дээш настай хүн амын гар утас, интернет хэрэглэдэг эсэх..... | 17 |
| Зураг 2.3. | Гар утас, интернет хэрэглэдэг хүн амын тоо, гар утас, интернетийг хоёуланг хэрэглэдэг байдал, мянган хүнээр | 17 |
| Зураг 2.4. | Гар утас хэрэглэгч, интернет холболтын тоо, 2005-2010 он | 18 |
| Зураг 2.5. | Үүрэн холбооны үйлчилгээний ярих тариф, хэрэглэгчийн тооны хамаарал..... | 19 |
| Зураг 2.6. | Гар утас хэрэглэгчийн нас, хүйсийн суварга..... | 20 |
| Зураг 2.7. | Зургаа, түүнээс дээш настай суурин хүн амд гар утас хэрэглэгчийн эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр..... | 21 |
| Зураг 2.8. | Интернет хэрэглэгч, интернет хэрэглэдэг хэлбэр, хувиар | 22 |
| Зураг 2.9. | Интернет хэрэглэгчийн нас, хүйсийн суварга..... | 22 |
| Зураг 2.10. | Зургаа, түүнээс дээш насны хүн амд интернет хэрэглэгчийн эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр | 23 |
| Зураг 2.11. | Зургаа, түүнээс дээш насны суурин хүн амд гар утас хэрэглэгчийн эзлэх хувь, аймаг, нийслэлээр...24 | |
| Зураг 2.12. | Суурин хүн амын тоо, зургаа, түүнээс дээш настай хүн амын гар утас хэрэглэх төвшин, байршилаар | 25 |
| Зураг 2.13. | Зургаа, түүнээс дээш настай суурин хүн амд интернет хэрэглэгчийн эзлэх хувь, аймаг, нийслэлээр..... | 26 |
| Зураг 2.14. | Суурин хүн амын тоо, зургаа, түүнээс дээш настай хүн амын интернет хэрэглэх төвшин, байршилаар | 27 |
| Зураг 2.15. | Зургаа, түүнээс дээш насны хүн амын тоо, боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгээр | 29 |
| Зураг 2.16. | Нийт хүн амд гар утасхэрэглэгчийн эзлэх хувь, боловсролын төвшин, хүйсээр | 29 |
| Зураг 2.17. | Нийт хүн амд интернет хэрэглэгчийн эзлэх хувь, боловсролын төвшин, хүйсээр.....31 | |
| Зураг 2.18. | Арван тав, түүнээс дээш настай хүн амын гар утасны хэрэглээ, гэр булийн байдал, хот, хөдөө, хувиар..... | 32 |
| Зураг 2.19. | Арван тав, түүнээс дээш настай хүн амын интернетийн хэрэглээ, гэр булийн байдал, хот, хөдөө, хувиар..... | 33 |
| Зураг 2.20. | Зургаа, түүнээс дээш насны хүн амд гар утас хэрэглэгчийн эзлэх хувь, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр..... | 34 |
| Зураг 2.21. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний гар утасны хэрэглээ, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хүйс, хувиар | 35 |
| Зураг 2.22. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний интернетийн хэрэглээ, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хүйс, хувиар | 36 |
| Зураг 2.23. | Гадаадын харьят иргэний тоо, гар утасны хэрэглээ, улс орноор | 37 |
| Зураг 2.24. | Гадаадын харьят иргэний тоо, интернетийн хэрэглээ, улс орноор..... | 38 |
| Зураг 3.4. | Арван тав, түүнээс дээш насны хүн амд гар утас хэрэглэгчийн эзлэх хувь, эдийн засгийн идэвхийн үзүүлэлтээр..... | 40 |
| Зураг 3.5. | Арван тав, түүнээс дээш насны хүн амд гар утас хэрэглэгчийн эзлэх хувь, эдийн засгийн идэвх, боловсролын төвшингөөр | 41 |



| | | |
|-------------|---|----|
| Зураг 3.6. | Хөдөлмөр эрхэлдэг хүн амын гар утасны хэрэглээ, ажил эрхлэлтийн байдлаар | 41 |
| Зураг 3.7. | Хөдөлмөр эрхэлдэг хүн амын гар утасны хэрэглээний төвшин, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлээр | 42 |
| Зураг 3.8. | Хөдөлмөр эрхэлдэг хүн амын гар утасны хэрэглээ, эрхэлдэг ажил мэргэжил, хувиар | 43 |
| Зураг 3.9. | Эдийн засгийн идэвхгүй хүн амын гар утасны хэрэглээ, хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан, хувиар..... | 44 |
| Зураг 3.10. | Арван тав, түүнээс дээш насны хүн амд интернет хэрэглэгчийн эзлэх хувь, эдийн засгийн идэвхийн үзүүлэлтээр | 44 |
| Зураг 3.11. | Арван тав, түүнээс дээш насны хүн амд интернет хэрэглэгчийн эзлэх хувь, эдийн засгийн идэвх, боловсролын төвшингөөр..... | 45 |
| Зураг 3.12. | Хөдөлмөр эрхэлдэг хүн амын интернетийн хэрэглээ, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр | 45 |
| Зураг 3.13. | Хөдөлмөр эрхэлдэг хүн амын интернетийн хэрэглээний төвшин, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлээр | 46 |
| Зураг 3.14. | Хөдөлмөр эрхэлдэг хүн амын интернетийн хэрэглээний төвшин, эрхэлдэг ажил мэргэжлээр.... | 47 |
| Зураг 3.15. | Эдийн засгийн идэвхгүй хүн амын гар утасны хэрэглээ, хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаанаар.. | 47 |
| Зураг 3.16. | Нийт өрхөд гар утасгүй өрхийн эзлэх хувь, аймаг нийслэлээр..... | 49 |
| Зураг 3.17. | Нийт өрхөд интернет холболттой өрхийн эзлэх хувийн жин, аймаг, нийслэлээр | 50 |
| Зураг 3.18. | Өрхийн тоо, орон сууцны төрлөөр | 51 |
| Зураг 3.19. | Зургаа, түүнээс дээш насны хүн амын интернет хэрэглээний төвшин, орон сууцны төрлөөр | 52 |

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | | |
|--------------|--|----|
| Хавсралт 1. | Гар утас, интернет, хоёуланг нь хэрэглэдэг хүн амын тоо, аймаг, нийслэл, хүйсээр..... | 64 |
| Хавсралт 2. | Зургаа, түүнээс дээш насны суурин хүн амд гар утас хэрэглэгчийн эзлэх хувь, хот, хөдөө, аймаг, нийслэл, хүйсээр | 64 |
| Хавсралт 3. | Зургаа, түүнээс дээш насны суурин хүн амд интернет хэрэглэгчийн эзлэх хувь, хот, хөдөө, аймаг, нийслэл, хүйсээр | 65 |
| Хавсралт 4. | Зургаа, түүнээс дээш насны суурин хүн амд гар утас, интернет, хоёуланг нь хэрэглэгчийн эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр | 65 |
| Хавсралт 5. | Зургаа, түүнээс дээш насны суурин хүн амд гар утас хэрэглэгчийн эзлэх хувь, аймаг, нийслэл, насны бүлэг, хүйсээр | 66 |
| Хавсралт 6. | Зургаа, түүнээс дээш насны суурин хүн амд интернет хэрэглэгчийн эзлэх хувь, аймаг, нийслэл, насны бүлэг, хүйсээр | 66 |
| Хавсралт 7. | Зургаа, түүнээс дээш насны суурин хүн амд гар утас хэрэглэгчийн эзлэх хувь, хот, хөдөө, байршил, аймаг, нийслэлээр | 67 |
| Хавсралт 8. | Зургаа, түүнээс дээш насны суурин хүн амд интернет хэрэглэгчийн эзлэх хувь, хот, хөдөө, байршил, аймаг, нийслэлээр | 67 |
| Хавсралт 9. | Зургаа, түүнээс дээш насны суурин хүн амд гар утас хэрэглэгчийн эзлэх хувь, аймаг, нийслэл, боловсролын төвшингөөр | 68 |
| Хавсралт 10. | Зургаа, түүнээс дээш насны суурин хүн амд интернет хэрэглэгчийн эзлэх хувь, аймаг, нийслэл, боловсролын төвшингөөр | 69 |
| Хавсралт 11. | Хөдөлмөр эрхэлдэг хүн амын гар утас, интернет хэрэглэх төвшин, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлээр | 71 |
| Хавсралт 12. | Ажил хайж байгаа хүн амын гар утас, интернет хэрэглэх төвшин, аймаг, нийслэл, хүйсээр..... | 72 |
| Хавсралт 13. | Эдийн засгийн идэвхгүй хүн амын гар утас хэрэглэх төвшин, хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан, аймаг, нийслэлээр | 74 |
| Хавсралт 14. | Эдийн засгийн идэвхгүй хүн амын интернет хэрэглэх төвшин, хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан, аймаг, нийслэлээр | 74 |
| Хавсралт 15. | Нийт хүн амд гар утас хэрэглэдэг хүн амын эзлэх хувь, орон сууцны төрөл, аймаг, нийслэлээр | 75 |
| Хавсралт 16. | Нийт хүн амд интернет хэрэглэдэг хүн амын эзлэх хувь, орон сууцны төрөл, аймаг, нийслэлээр .. | 75 |
| Хавсралт 17. | Нийт хүн амд гэртээ байнга интернет хэрэглэдэг хүн амын эзлэх хувь, орон сууцны төрөл, аймаг, нийслэлээр..... | 76 |
| Хавсралт 18. | Нийт хүн амд бусад газарт байнга интернет хэрэглэдэг хүн амын эзлэх хувь, орон сууцны төрөл, аймаг, нийслэлээр..... | 76 |
| Хавсралт 19. | Нийт хүн амд шаардлагатай үед интернет хэрэглэдэг хүн амын эзлэх хувь, орон сууцны төрөл, аймаг, нийслэлээр..... | 77 |



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|--------|--|
| МШХХТГ | Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо технологийн газар |
| ХХЭХ | Харилцаа холбооны зохицуулах хороо |
| МХХТ | Мэдээлэл, харилцаа холбооны технологи |
| ҮСХ | Үндэсний Статистикийн Хороо |
| ОУХХБ | Олон Улсын Харилцаа Холбооны Байгууллага /International Telecommunication Union/ |
| ISP | Интернетийн үйлчилгээ үзүүлэгч /Internet service provider/ |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |

ӨМНӨХ ҮГ



Дэлхий нийтэд мэдээлэл, харилцаа холбооны технологи асар хурдацтай хөгжиж байгаа энэ үед Монгол улсад 1996 оноос хойш гар утас, интернетийн хэрэглээ мөн хурдацтай хөгжиж байна.

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийг Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн ХХI зууны хурдасгуур гэж үзсэн.

Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийн явцыг тодорхойлоход Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор анх удаа гар утас, интернет хэрэглэдэг эсэх мэдээллийг б, түүнээс дээш настай нийт хүн амаас асуусан нь чухал ач холбогдолтой болсон.

“Гар утас, интернет хэрэглэгчийн тоо бүтэц” сэдэвчилсэн судалгаа нь Монгол Улсын хүн амын гар утас, интернетийн хэрэглээг нас хүйс, байршил, нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлттэй харьцуулан судалж буй анхны судалгаа болж байгаагаараа онцлогтой. Сэдэвчилсэн судалгааны дүнгээс үзэхэд Монголчуудын интернетийн болон үүрэн телефоны байнгын хэрэглээнд ихээхэн дэвшил гарсныг харуулж байна. Энэхүү сэдэвчилсэн судалгааны үр дүн нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн ирээдүйн хөгжил, үүний дотор интернет, гар утасны хэрэглээг улам нэмэгдүүлэх орчин үеийн мэдээлэл харилцаа холбооны техникийн дэвшлийг нэвтрүүлэх бодлого төлөвлөлтөд чухал ач холбогдолтой болжээ.

УНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ ТООЛЛОГЫН
УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА,

 С. МЭНДСАЙХАН



НЭГЛҮГЭЭР БУЛЭГ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ



1.1 ОРШИЛ

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш 6 жилийн дараа мэдээлэл харилцаа холбооны салбарт томоохон хөрөнгө оруулалт хийснээр гар утас, интернетийн үйлчилгээний үндэс суурь тавигдсан. Ахь Мобиком корпораци /1996/ монголчуудад гар утас хэрэглэх боломжийг олгож дараагаар Скайтел /1999/, Юнител /2006/, Жи-Мобайл /2007/ компани байгуулагдаж, харилцаа холбооны чиглэлээр ард түмний хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэж байна.

Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (ХХЗХ)-ноос гаргасан мэдээллээр 2010 онд 2.5 сая хүн гар утас хэрэглэж байгаа нь 2002 оноос 10 дахин өссөн үзүүлэлт юм. Түүнчлэн хэрэглэгчид байршилын ялгааны хувьд улам тэлж хэдхэн жилийн өмнө зөвхөн хот, суурин газрын хүмүүсийн хэрэглээ байсан гар утас өдгөө алслагдсан хөдөө орон нутагт хүртэл хэрэглэх боломжтой болжээ.

1996 оны 1 дүгээр сарын 17-нд Монгол Улсад анхны интернетийн үйлчилгээний суурь тавигдаж, өнөөдөр ХХЗХ-ноос интернетийн үйлчилгээг үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан 70 гаруй аж ахуй нэгжийн 20 нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна. 2010 оны байдлаар интернет холболт 199.8 мянгад хүрч 2005 онтой харьцуулахад 22 дахин өссөн үзүүлэлт болж байна. Ийнхүү “200.0 мянга орчим интернет холболттой цэгийн 80 гаруй хувь нь шилэн кабель, 3G, EVDO, GPRS, WIMAX гэх мэт утасгүй холбооны технологийг ашигладаг юм”¹. Хот суурин газрын хүмүүс өдгөө албан байгууллага, интернет кафе, сургууль болон гэрээсээ интернетийн үйлчилгээг авах боломжтой болжээ. Манай улсын гар утас, интернетийн хэрэглээ жил ирэх тутам өсч байгааг харж болно.

Гар утас, интернетийн хэрэглээ нь харилцаа холбооны дэд бүтцийн² хөгжилтэй холбоотой бөгөөд 2010 оны байдлаар үүрэн холбооны сүлжээ Монгол Улсын бүх сум, суурин газрын төв 100 хувь, харин шилэн кабелийн сүлжээ 21 аймгийн төв болон 138 сум, суурин газар хамраад байна.

“Харилцаа холбооны тухай” Монгол Улсын хууль, 2005 онд Засгийн газрын тогтоолоор баталсан “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр, 2008 онд Улсын Их Хурлын тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурин Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт интернет, гар утасны хэрэглээг дэмжсэн хууль эрх зүйн заалт оржээ. Алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд харилцаа холбоог хүргэх зорилго бүхий бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, улс орныг хамарсан мэдээлэл, харилцаа холбооны өндөр хурдны нэгдсэн сүлжээ байгуулах, мэдээлэл, харилцаа холбооны салбарт бизнесийн шударга өрсөлдөөнийг бий болгох, улмаар мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг айл бүрт хүртээмжтэй болгох зэрэг асуудлыг тусгасан байна.

Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч компаниудын зах зээлийн судалгаа, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын зарим нэг мэдээллээс өөр гар утас, интернетийн хэрэглээний талаарх улсын хэмжээний судалгаа хараахан байхгүй байна. “Гар утас, интернет хэрэглэгч: тоо, бүтэц” сэдэвчилсэн судалгаа нь Монгол Улсын хүн амын интернет, гар утасны хэрэглээг нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлттэй харьцуулж буй анхны судалгаа болж байгаагаараа онцлогтой юм.

¹ МШХХТГ, ХХЗХ, Монгол Улсын МХХТ-ийн талаар 2021 он хүртэл төрөөс баримтлах бодлогын судалгаа, УБ, 2011, 80 дахь талаас үзнэ үү.

² МХХТ-ийн сүлжээнд хамрагдсан байдал

1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Эл судалгааны зорилго нь Монгол Улсын хүн амын гар утас, интернетийн хэрэглээний өнөөгийн төвшин, нөлөөлөх хүчин зүйлс, хамаарлыг тодорхойлж гар утас, интернет хэрэглэгчийн талаар цаашид төр, засгаас баримтлах бодлого зөвлөмж боловсруулахад ашиглах шаардлагатай мэдээллийн эх үүсвэр бүрдүүлэхэд оршино.

Үүнд хүрэхийн тулд дараах зорилтыг тавьж байна.

- Гар утас, интернет хэрэглэгчийн тоо, бүтцийг тодорхойлох;
- Хэрэглээний ялгаатай байдлыг харуулах;
- Өрхийн гар утас, интернетийн хэрэглээ болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох;
- Гар утас, интернетийн хэрэглээг сайжруулахад чиглэсэн төр, засгийн бодлого боловсруулахад шаардлагатай мэдээлэл бүрдүүлэх, бодлогын чанартай зарим санал, зөвлөмжийг дэвшүүлнэ.

1.3 СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, АГУУЛАМЖ

Сэдэвчилсэн судалгаанд хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор цуглуулсан тоон мэдээлэлд үндэслэн гар утас, интернет хэрэглэгчийг:

- Нас, хүйс
- Боловсрол
- Гэр булийн байдал
- Хөгжлийн бэрхшээлийн байдал
- Гадаадын харьяат иргэн
- Ажил эрхлэлттэй хамруулан судалж, тархалтын давтамжийг тайлбар статистикийн аргаар шинжлэв. Үүний зэрэгцээ гар утас, интернетийг хоёуланг хэрэглэдэг хүн амын тоог гаргасан.

Олон улсын стандартын дагуу 100 хүнд ногдох гар утас, интернет хэрэглэгчийг гаргаж аймаг, нийслэл, хот, хөдөөгийн төвшинд харьцуулж үзсэн. Улмаар Монгол Улсын гар утас, интернетийн хэрэглээний өнөөгийн төвшинг олон улсын холбогдох байгууллагын бус нутгийн мэдээлэлтэй харьцуулав. Түүнчлэн өрхийн гар утас, интернетийн хэрэглээний төвшинг тусгайлан авч үзэв. Эцэст нь гар утас, интернетийн хэрэглээний төвшинд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээг хийсэн болно.

1.4 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын асуулгыг нөхөх заавар, тооллогын үндсэн үр дүнгийн тайландаа тусгасан ойлголт, тодорхойлолтыг хэрэглэгчид ойлгомжтой болгохын тулд дараах нэр томьёог ашиглав. Үүнд:

Гар утас хэрэглэдэг хүн/хэрэглэгч

Үүрэн технологид сууринсан, нийтийн телефон сүлжээнд (үүрэн холбооны оператор) холбогдсон авсаархан, зөвөврийн телефон (гар утас) хэрэглэгчийг үүрэн утас хэрэглэгч гэнэ. Тухайн хүн өөрийн гэсэн үүрэн утас болон үүрэн утасны дугаартай бол гар утас хэрэглэгч гэж үзнэ. Харин дугаартай боловч утасгүй, утастай боловч дугааргүй тохиолдолд гар утасгүй гэж үзэв.



Интернет хэрэглэдэг хүн/ хэрэглэгч

Телефон утас болон түрээсийн шугам, өндөр хурдны хэрэглэгчийн тоон шугам буюу ДиЭсЭл (DSL), ЭйДиЭсЭл (ADSL), байнгын гарцтай, өндөр хурдны кабель modem, шилэн кабель хэрэглэгчийг интернетийн байнгын хэрэглэгч гэнэ.

Интернет хэрэглэгчийг дотор нь:

Гэртээ байнга хэрэглэдэг: Гэрээсээ интернетэд холбогдог иргэнийг хамааруулав.

Гэрээсээ бусад газарт байнга хэрэглэдэг: Энэ ангилалд ажил дээрээ болон интернет кафегаар тогтмол (7 хоногт хамгийн багадаа 5 өдөр нь) үйлчлүүлдэг хүмүүсийг хамааруулав.

Гэрээсээ бусад газарт шаардлагатай үед хэрэглэдэг: Интернет кафегаар хааяа үйлчлүүлдэг аав, ээж, ах дүү, найз нөхдийн гэр болон ажил дээр шаардлага гарсан үед интернет хэрэглэдэг иргэнийг хамааруулав.

Үгүй: Интернетийг ямар нэгэн байдлаар огт хэрэглэдэггүй иргэнийг хамааруулав.

Гар утас, интернет хэрэглэх төвшин

Зургаа, түүнээс дээш насны хүн амд гар утас, интернет хэрэглэгчийн эзлэх хувийн жинг илтгэнэ. Энэхүү мэдээллийг олон улсын төвшинд 100 хүнд ногдох гар утас, интернет хэрэглэгчийн тоо, гар утас, интернет нэвтрэх хувь гэж нэрлэдэг. Интернет хэрэглэгчийн хувьд ямар нэгэн байдлаар (гэртээ болон бусад газар байнга, шаардлагатай үед) интернет хэрэглэдэг гэсэн бол тухайн хүнийг интернет хэрэглэдэг гэж үзэн тооцсон.

Эдийн засгийн идэвхитэй хүн ам

Ажил эрхэлж байгаа болон ажилгүй боловч ажил хайж байгаа хүн амын нийлбэр.

Эдийн засгийн идэвхигүй хүн ам

Тооллогын өмнөх 7 хоногт дараах шалтгааны улмаас хөдөлмөр эрхлэхгүй байгаа хүнийг хамрав.

- Сургуульд сурдаг
- Тэтгэвэрт
- Хөдөлмөр эрхлэх чадваргүй
- Гэрийн ажилтай
- Тохирох ажил олдохгүй байгаа
- Ажиллах сонирхолгүй
- Бусад

Интернет холбосон өрх

Гэрээсээ интернетийн үйлчилгээг авах боломжтой өрх. Үүнийг гэртээ байнга интернет хэрэглэдэг нэг болон түүнээс дээш хүнтэй өрхийн тоогоор тооцсон.

ХОЁРЛУГААР БҮЛЭГ

ГАР УТАС, ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ




“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д МХХТ-ийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн ХХI зууны үндсэн хурдасгуур гэж үзсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- Хөдөө орон нутагт утасгүй холбооны системийг эрчимтэй хөгжүүлж, 2015 он гэхэд үүрэн телефоны шинэ үеийн үйлчилгээг газрын суурь сүлжээг ашиглан хүн амын 60 хүртэл хувьд хүргэж, газар нутгийн 50 хүртэл хувийг зөвхөн газрын суурь сүлжээний тусламжтайгаар хамруулах;
- 2021 он гэхэд бүх сум, сууринг шилэн кабелийн болон бага оврын тоон радиорелейн сүлжээгээр холбож, төрийн болон арилжааны цахим үйлчилгээг хүлээн авах боломжийг хөдөөгийн хүн амын 70 хүртэл хувьд хүргэх;
- 2021 онд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 95 хүртэл хувьд суурин болон хөдөлгөөнт хэлбэрээр мэдээлэл, харилцааны технологийн үйлчилгээг хүн бүр хүлээн авах боломжийг бүрдүүлэх.


Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд гар утас, интернет хэрэглэгчийн тоог тодорхойлох шаардлагатай болсон. Энэ шаардлагын дагуу хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор анх удаа гар утас, интернет хэрэглэдэг эсэх мэдээллийг бүрхэндээш насны бүх хүнээс асуусан болно.

ЗУРАГ 2.1. ГАР УТАС, ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭГ ТОДОРХОЙЛОХ АСУУЛТ, ХАРИУЛТЫН БҮДҮҮВЧ



Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр 2647.5 мянган суурин хүн тоологдсон бөгөөд үүний 87.5 хувь буюу 2315.6 мянга нь 6, түүнээс дээш насны хүн байв. Эдгээр хүний 74.0 хувь буюу 1714.6 мянган хүн гар утас хэрэглэдэг гэсэн үр дүн гарчээ. Зургаа, түүнээс дээш настай дөрвөн хүн тутмын гурав нь гар утас хэрэглэдэг байна. Харин 30.6 хувь буюу 709.6 мянган иргэн интернет хэрэглэдэг нь гурван хүн тутмын нэг нь л интернетийг ямар нэгэн байдлаар хэрэглэдэг ажээ.

ЗУРАГ 2.2. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ГАР УТАС, ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭДЭГ ЭСЭХ



Олон Улсын Харилцаа Холбооны Байгууллага (ОУХХБ/ ITU)-аас жил бүр гаргадаг статистик мэдээний дүнгээс харвал, 2010 оны байдлаар дэлхийн 100 хүнд ногдох гар утас хэрэглэгчийн тоо 78, хөгжих буй оронд 70.1, хөгжингүй оронд 114.2, Азийн оронд 69.2 байна³. Манай улсын 100 хүнд ногдох гар утас хэрэглэгчид дэлхийн дунджаас 4.0 пунктээр доогуур, харин хөгжих буй орноос 3.9 пункт, Азийн орноос 4.8 пунктээр тус тус дээгүүр байна. 100 хүнд ногдох интернет хэрэглэгчийн тоогоор дэлхийн дунджаас 0.9 пункт, хөгжих буй орны дунджаас 9.5 пункт, Азийн орны дунджаас 13.8 пунктээр тус тус дээгүүр байна.

Зураг 2.3-аас харахад хүн ам, орон сууцны тооллогод хамрагдсан 6, түүнээс дээш настай хүний 74 хувь нь гар утас хэрэглэж, 30.6 хувь нь интернетийг ямар нэгэн байдлаар ашиглаж байгаа бол 29.6 хувь буюу 685.2 мянган хүн гар утас, интернетийг хоёуланг хэрэглэж, 24.9 хувь буюу 576.7 мянган хүн гар утас, интернетийг аль алийг хэрэглэдэггүй байна. 4 хүн тутмын 1 нь мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг авдаггүй гэсэн үг юм (Зураг 2.3.Б).

Интернет хэрэглэдэг хүний 96.6 хувь нь гар утас давхар ашигладаг бол үлдсэн 24.3 мянган хүн нь зөвхөн интернет хэрэглэж байна. Ганц интернет хэрэглэж буй хүний 70 хувь нь (17.4 мянган хүн) 18, түүнээс доош насныхан байна. Харин гар утас хэрэглэдэг 1714.6 мянган хүний 60.0 хувь нь (1029.3 мянган хүн) ганц гар утас хэрэглэж байгаа нь тоологоос харагдаж байна. Эндээс интернет хэрэглэдэг хүн бүр гар утас хэрэглэдэг гэж үзэж болно.

ЗУРАГ 2.3. ГАР УТАС, ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭДЭГ ХҮН АМЫН ТОО, ГАР УТАС, ИНТЕРНЕТИЙГ ХОЁУЛАНГ ХЭРЭГЛЭДЭГ БАЙДАЛ, МЯНГАН ХҮНЭЭР



3 ITUWorld Telecommunication/ICT Indicators database –<http://www.itu.int/ITU-D/ict/statistics/index.html> 2011.11.11-ний мэдээллээс аяае.

| | Гар утас хэрэглэгч /мян/ | Интернет хэрэглэгч /мян/ |
|---|-----------------------------|-----------------------------|
| Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого | 1714.6 | 709.6 |
| Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдээ | 2510.4 | 800.0 |

2010 оны ХХЗХ-ны албан ёсны мэдээллээс үзэхэд манай улсын гар утас хэрэглэгч 2.5 сая, интернет хэрэглэгч 800.0 мянгад хүрчээ. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын үр дүнгээс гар утас хэрэглэгч 795.8 мянга, интернет хэрэглэгч 90.4 мянгаар тус тус их байна.


Тооллогын үр дүн, ХХЗХ-оос гаргасан мэдээллийн зөрүүг дараах байдлаар тайлбарлай. Үүнд:

Нэгд, Хүн ам орон сууцны 2010 оны улсын тооллогод 6, түүнэс дээш настай нийт хүнээс зөвхөн гар утас хэрэглэдэг эсэх мэдээллийг цуглуулсан. Тухайн хариулагчаас хэдэн гар утас хэрэглэж байгаа буюу давхар дугаар хэрэглэдэг болохыг тодруулаагүй. Дээрх мэдээллийн зөрүүг давхар дугаартай хэрэглэгчээс улбаатай гэж үзвэл тооллогод хамрагдсан 2 хүн тутмын нэг нь 2, түүнээс дээш гар утас хэрэглэж байна гэж хэлж болно.

Хоёрт, асуулгад хамрагдаагүй 6 хүртэлх насны хүүхдийн дунд тодорхой хэмжээний гар утас, интернетийн хэрэглээ байх талтай.

Гуравт, ХХЗХ-ны мэдээлэл нь гар утасны үйлчилгээ үзүүлэгч оператор компаниудаас улирал бүр ирүүлдэг хэрэглэгчийн мэдээлэл дээр үндэслэдэг. Иймээс дээрх тооны зөрүү нь нэг талаас оператор компаниуд өөрсдийн хэрэглэгчийг бодитой бус өсгөж мэдээлдэгтэй холбоотой байж болох юм.


ЗУРАГ 2.4. ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧ, ИНТЕРНЕТ ХОЛБОЛТЫН ТОО, 2005-2010 ОН



Эх үүсвэр: МШХХТГ, ХХЗХ, Монгол Улсын МХХТ-ийн талаар 2021 он хүртэл төрөөс баримтлах бодлогын судалгаа, УБ, 2011, 62 дахь талаас үзнэ үү.

Манай улсын хүн ам гар утас, интернет хэрэглэх нь харьцангуй өндөр байна. Энэ нь 2006 онд гуравдагч, дөрөвдөгч үүрэн холбооны оператор болон интернетийн үйлчилгээ үзүүлэгч (Internet Service Provider/ISP) компани уг салбарт ажиллаж, зах зээлийн өрсөлдөөн ширүүсч, улмаар үйлчилгээний үнэ тариф тодорхой хэмжээгээр буурсантай холбоотой юм.

ЗУРАГ 2.5. ҮҮРЭН ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЯРИХ ТАРИФ, ХЭРЭГЛЭГЧИЙН ТООНЫ ХАМААРАЛ



Эх үүсвэр: ХХЗХ, УСХ-ны статистик мэдээлэл

2.1 НАС, ХҮЙСИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ


2.1.1 ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор 6, түүнээс дээш насны 2315.6 мянган хүн бүртгэгдсэний 49.5 хувь буюу 1145.2 мянган эрэгтэй, 50.5 хувь буюу 1170.4 мянган эмэгтэй хүн байна.

Тооллогын товын хугацаа буюу 2011 оны 11-р сарын 10-ны байдлаар Монгол Улсын 6, түүнээс дээш насны суурин хүн амын 74 хувь буюу 1714.6 мянган иргэн гар утас хэрэглэж байна. Нийт гар утас хэрэглэгчийн 48 хувь (826.8 мянга) нь эрэгтэй, 52 хувь (887.7 мянга) нь эмэгтэй хүн ам байна.

Тооллогод хамрагдсан зорилтод насны нийт эрэгтэй хүн амын 72.2 хувь, эмэгтэй хүн амын 75.9 хувь нь гар утас ашиглаж байна. Эмэгтэйчүүдийн гар утасны хэрэглээ эрэгтэйчүүдээс 3.6 пунктээр дээгүүр байна. Гар утас хэрэглэгчийн нас, хүйсийн суваргыг Зураг 2.6-д харуулав.


ЗУРАГ 2.6. ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА



Гар утас хэрэглэгчийг аймгийн төвшинд хүйсийн ялгаатай байдлаар авч үзэхэд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгуудын эрэгтэйчүүдийн гар утасны хэрэглээ нь эмэгтэйчүүдийнхээс бага зэрэг дээгүүр байна. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн хувьд эрэгтэйчүүдийн гар утасны хэрэглээ нь эмэгтэйчүүдийнхээс 6.4 хувиар илүү байна. Гэтэл Дундговь аймгийн эмэгтэйчүүдийн гар утасны хэрэглээ нь эрэгтэйчүүдийнхээс 7.2 пунктээр илүү байгаа нь бусад аймгуудтай харьцуулахад өндөр байна.

ОУХХБ-аас гаргасан судалгаагаар Европын дийлэнх орны эрэгтэйчүүдийн мэдээлэл харилцаа холбооны хэрэглээ нь эмэгтэйчүүдийнхээс дээгүүр байдаг бол манай улсад уг үзүүлэлт эсрэгээр байна. Харин 65-аас дээш насанд эрэгтэй хүний гар утасны хэрэглээ эмэгтэйчүүдийнхээс бага зэрэг өндөр байна.

ЗУРАГ 2.7. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ СУУРИН ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР



Зураг 2.7-оос харахад 15-59 насны хүн амын гар утас хэрэглэх төвшин нь улсын дунджаас өндөр байна. 6-19 насны өсвөр үеийнхний нас дээшлэх тутам гар утасны хэрэглээ нь дагаад өсч байна. Энэ нь нэг талаас эцэг, эхчүүд хүүхдээ бие даах чадвартай болмогц тэдний гар утасны хэрэглээг нь дэмждэг, нөгөө талаас өсвөр насны хүүхдийн сонирхол, гар утастай нэгнээ даган дуурайх хандлага нөлөөлсөн байж болох юм.

Гар утас хэрэглэх төвшинг насны бүлгээр тооцож үзэхэд 20-24 насны бүлэг дэх гар утасны хэрэглээ (100 хүнд 88) бусад насны бүлэгтэй харьцуулахад хамгийн их байхад, 6-9 насны бүлгийн хувьд (100 хүнд 23) хамгийн бага байна.


Энэхүү үзүүлэлтийг аймаг, нийслэлээр авч үзэхэд нэлээд ялгаатай байна. Тухайлбал, Архангай, Баян-Өлгий, Булган, Дорноговь, Төв, Ховд, Улаанбаатар, Дархан-Уул аймагт улсын дундажтай адилдаар 20-24 насныхы гар утасны хэрэглээ бусад бүлэгтэй харьцуулахад дээгүүр байна. Харин Өмнөговь, Сэлэнгэ, Увс, Орхон аймагт 25-29 нас, Баянхонгор, Говьсүмбэр, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт 30-34 нас, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хөвсгөл аймагт 35-39 насныхы гар утасны хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад дээгүүр байна. Энэ нь тухайн аймгийн хүн амын насны бүтэц, байршил, боловсрол, хөдөлмөр эрхлэлт зэрэг хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлстэй холбоотой байх магадлалтай.

Манай улсын гар утас хэрэглэгчийн голч нас нь 30 бөгөөд нийт гар утас хэрэглэж байгаа хүмүүсийн тэн хагас буюу 857.3 мянга нь 30 хүртэл, үлдсэн хувь нь 30-аас дээш насны хүн байна гэсэн үг юм. Энэ нь 6, түүнээс дээш настай хүн амын голч настай (25 нас) харьцуулахад 5 насаар дээгүүр байгаа бөгөөд ахмад насныхы гар утасны хэрэглээ харьцангуй өндөр байгааг илтгэнэ.

2.1.2 ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ


Тооллогын үед Монгол Улсын 6, түүнээс дээш настай суурин хүн амын 30.6 хувь буюу 709.6 мянган иргэн интернет хэрэглэж байна. Интернет хэрэглэдэг хүн амын 32.3 хувь гэртээ, 20.3 хувь бусад газар, 47.3 хувь шаардлагатай үед интернет хэрэглэдэг гэж хариулсан байна. Эндээс үзэхэд интернет хэрэглэдэг хүмүүсийн бараг тал хувь нь шаардлагатай үедээ интернет кафе, эсвэл төрөл садан, найз нөхдийнхөө гэр болон ажлын газарт интернет хэрэглэж байна.

ЗУРАГ 2.8. ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧ, ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭДЭГ ХЭЛБЭР, ХУВИАР



Интернет хэрэглэдэг гэж хариулсан хүмүүсийг хүйсээр авч үзэхэд 46 хувь буюу 325.3 мянга нь эрэгтэй, 54 хувь буюу 384.2 мянга нь эмэгтэй хүн байна. Тооллогод хамрагдсан 6, түүнээс дээш настай эрэгтэй хүний 28.4 хувь, эмэгтэй хүний 32.8 хувь нь интернет хэрэглэж байгаагаас харахад эмэгтэйчүүдийн интернетийг хэрэглэх нь эрэгтэйчүүдийнхээс 4.4 хувиар дээгүүр байна. Түүнчлэн интернетийн хэрэглээ нь хүйсийн ялгаатай байдал болон насны бүлгээр харьцангуй өөр байна. Тухайлбал, эдийн засгийн идэвхтэй 15-59 насны эмэгтэйчүүд интернет хэрэглэх нь эрэгтэйчүүдийнхээс 9.7 хувиар дээгүүр бол эсрэгээр 15 хүртэлх болон 60, түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн интернет хэрэглэх (15.9 хувь) нь эмэгтэйчүүдийнхээс (14.4 хувь) бага зэрэг дээгүүр байна.


ЗУРАГ 2.9. ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА



Интернет хэрэглэгчийг хүйсийн байдлаар аймгийн төвшинд авч үзэхэд эмэгтэйчүүд интернет хэрэглэх нь эрэгтэйчүүдийнхээс дээгүүр байна. Тухайлбал, Дорноговь аймгийн эмэгтэйчүүдийн хэрэглээ эрэгтэйчүүдийнхээс 6 пунктээр өндөр байгаа нь бусад аймагтай харьцуулахад өндөр нь байна. Архангай, Дорнод, Төв, Дархан-Уул зэрэг аймгийн эмэгтэйчүүд интернет хэрэглэх нь эрэгтэйчүүдийнхээс 4.5-4.9 пунктээр дээгүүр байгаа нь улсын дунджаас (эрэгтэй 28.4, эрэгтэй 32.8) өндөр үзүүлэлт юм. Гэтэл Өмнөговь аймгийн хувьд уг үзүүлэлт эсрэгээр буюу эрэгтэйчүүдийн хэрэглээ нь эмэгтэйчүүдийнхээс 1.4 хувиар илүү байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь сүүлийн жилд уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж тус аймаг руу чиглэсэн ажиллах хүчний хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой болов уу. Тодруулбал, Хүн ам, орон сууцны тоологоор тухайн орон нутагт 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа хүнийг суурин хүн амд оруулсан. Өмнөговь аймгийн суурин хүн амын 58.1 хувь буюу 31.5 мянга нь эрэгтэй хүн ам байгаа нь улсын дунджаас 8.6 пунктээр дээгүүр үзүүлэлт юм.

Зургаа, түүнээс дээш настай хүн амд интернет хэрэглэгчийн эзлэх хувь насны хувьд харьцангуй ялгаатай байна. 15-29 насныхны интернет хэрэглэх төвшин нийт хүн амын интернет хэрэглэх төвшингөөс (18 пункт) дээгүүр байна.

ЗУРАГ 2.10. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР



Тооллогогоор 6-9 насны хүний 7.7 хувь буюу 13.2 мянга нь интернет хэрэглэж байна. Энэ насны интернет хэрэглэдэг хүүхдийн 63.5 хувь нь гэртээ, 9.3 хувь нь бусад газарт, 27.2 хувь нь шаардлагатай үед хэрэглэдэг гэсэн байна. Харин 10-14 насны хүн амын 25.8 хувь (60.3 мянган хүн) интернет хэрэглэдэг бөгөөд 34.6 хувь нь гэртээ, 14.1 хувь нь бусад газарт, 51.4 хувь нь шаардлагатай үед хэрэглэдэг гэжээ. Эндээс үзэхэд 6-9 насны интернет хэрэглэдэг хүүхдийн дийлэнх хувьд нь гэрт нь интернет байдаг учир түүнийг хэрэглэдэг байж болох юм. Түүнчлэн 6-14 насны эрэгтэй хүүхдийн интернетийн хэрэглээ эмэгтэй хүүхдийнхээс бага зэрэг дээгүүр байгаа нь эрэгтэй хүүхдийн интернет тоглоом тоглодогтой холбоотой байж болох талтай.

Нас ахих тутам интернет хэрэглээ буурч байгаа нь манай улсад интернетийн үйлчилгээ нэвтрээд 15 жил болж байгаа, нөгөө талаас, тухайн насны хүн амын компьютерийн мэдлэг болон хэрэглээ бага байдагтай холбоотой.

Манай улсын интернет хэрэглэдэг хүний 50 хувь нь 25 хүртэлх насны хүн байгаа нь хүн амын голч настай адил байна. Интернет хэрэглэгчийн дийлэнх хувь нь өсвөр үеийнхэн болон залуучууд байна.

2.2. БАЙРШИЛ, ТАРХАЛТ, ХОТ, ХӨДӨӨГИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

2.2.1 ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор 6, түүнээс дээш насны суурин хүн амын 67.8 хувь буюу 1570.2 мянган хүн хотод⁴, 32.2 хувь буюу 745.4 мянган хүн хөдөө⁵ амьдарч байна. Үүнийг байршилаар үзүүл хүн амын 44 хувь буюу 1018.1 мянган хүн нийслэл хотод, 21 хувь буюу 486.7 мянган хүн аймгийн төвд, 3 хувь буюу 65.4 мянган хүн тосгонд, 13 хувь буюу 306.1 мянган хүн сумын төвд, 19 хувь буюу 439.2 мянган хүн хөдөө амьдарч байна.

ЗУРАГ 2.11. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ СУУРИН ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР




Аймаг, нийслэлийн 6-аас дээш настай нийт суурин хүн амд гар утас хэрэглэгчийн эзлэх хувь Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Говьсүмбэр, Дорноговь аймаг улсын дунджаас дээгүүр (0.3-12.9 пункт) байна. Харин Баян-Өлгий аймагт гар утасны хэрэглээ хамгийн доогуур буюу 37.5 хувьтай байгаа бол Архангай аймагт гар утасны хэрэглээ 52.8 хувь, Сүхбаатар аймагт гар утасны хэрэглээ 53 хувиар удаалж байна. Ерөнхийдөө баруун бүсийн аймгийн гар утасны хэрэглээ (53 хувь) хамгийн доогуур байгаа бол төвийн бүсийн аймгуудын хэрэглээ (75 хувь) дээгүүр байна.

Гар утас хэрэглэгчийг байршилаар нь ангилж үзэхэд нэлээд ялгаатай тал байна. Тухайлбал, суурин хүн амын 67.8 хувь хот суурин газарт оршин сууж байхад гар утас хэрэглэгчийн 83.1 хувь хотод амьдарч байгаа нь нэлээд өндөр үзүүлэлт юм. Тооллогоор тухайн орон нутагт 6, түүнээс дээш сарын хугацаагаар сууж байгаа хүнийг суурин хүн амд хамруулсантай холбоотойгоор хот, суурин газарт суралцдаг оюутан, сурагчдын гар утасны хэрэглээ энэ үзүүлэлтийг өндөр байхад нөлөө үзүүлсэн байж болох юм.

⁴ Нийслэл хот, аймгийн төв, тосгон

⁵ Сумын төв, хөдөө

ЗУРАГ 2.12. СУУРИН ХҮН АМЫН ТОО, ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ГАР УТАС ХЭРЭГЛЭХ ТӨВШИН, БАЙРШЛААР



Нийслэлд амьдардаг хүн амын 86.9 хувь гар утас хэрэглэдэг бол аймгийн төвд 77.1 хувь, тосгонд 73.4 хувь байна. Гэтэл сумын төвд уг үзүүлэлт 64.2 хувь, хөдөөд 47.5 хувьтай байна. Энэ нь мэдээж гар утасны сүлжээний хамрах хүрээтэй холбоотой.

Аймгийн төвийн хүн амын гар утасны хэрэглээг аймгийн төвшинд авч үзэхэд Дархан-Уул, Орхон, Өмнөговь, Дорноговь, Сэлэнгэ аймагт хамгийн өндөр буюу 80-аас илүү хувьтай байхад харин Баян-Өлгий аймаг 60 хувь, Увс аймаг 69 хувьтай байгаа нь хамгийн доогуур байна. Сумын төвийн хүн амын гар утас хэрэглэх төвшин Баян-Өлгий (43.9 хувь), Увс (55.6 хувь), Сүхбаатар (56.6 хувь) аймагт хамгийн бага үзүүлэлттэй байна. Бусад аймгийн сумын төвд амьдрагчдын 60-аас илүү хувь гар утас хэрэглэж байна. Эндээс үзэхэд аймгийн төв, тосгон, сумын төвд амьдардаг хүн амын гар утасны хэрэглээ улсын дунджид ерөнхийдөө ойрхон байгаа бол хөдөөгийн хүн амын гар утасны хэрэглээ улсын дунджаас 26.2 пунктээр доогуур байна. Өөрөөр хэлбэл, гар утас хэрэглэх төвшин тухайн хүний хот, хөдөө амьдарч байгаагаас хамааран ялгаатай байгааг илтгэнэ.

Улсын хэмжээнд аймгийн нийт хүн амын 40-өөс илүү хувь нь хөдөө амьдардаг нийтдээ 9 аймаг (Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Өмнөговь, Говь-Алтай, Сүхбаатар, Төв, Хөвсгөл) байна. Эдгээр аймгийн хөдөөгийн хүн амын гар утас хэрэглэх төвшин хоорондоо ялгаатай байна. Тухайлбал, нийт хүн амын 43.8 хувь нь хөдөө амьдардаг Өмнөговь аймгийн хөдөөгийн хүн амын гар утасны хэрэглээ 73.5, Төв аймгийн хөдөөгийн хүн амын 64.5 хувь нь гар утас хэрэглэж байгаа нь бусад 7 аймагтай харьцуулахад өндөр байна. Гэтэл нийт хүн амын 45 хувь хөдөө амьдардаг Баян-Өлгий аймгийн хөдөөгийн хүн амын дөнгөж 17.1 хувь, Сүхбаатар аймгийн хөдөө амьдрагчдын 36.7 хувь нь гар утас хэрэглэж байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм. Мөн Архангай аймгийн 6, түүнээс дээш настай хүн амын 53 хувь буюу 39.1 мянган хүн хөдөө амьдардаг ба тэдний 39.1 хувь нь гар утас хэрэглэдэг аж. Эндээс үзэхэд хөдөө амьдрагчдын гар утасны хэрэглээнд үүрэн холбооны үйлчилгээ үзүүлдэг оператор компаниудын сүлжээ орсон эсэх, тухайн хүн амын амьжиргааны төвшин, гар утас ашиглах хэрэгцээ шаардлага байгаа эсэхээс шууд хамааралтай байна гэж үзэж болох юм.

2.2.2 ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧ


Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор б, түүнээс дээш настай хүний 30.6 хувь нь интернет хэрэглэж байна. Үүнийг аймаг, нийслэлээр интернет хэрэглэгчийн эзлэх хувийн жингээр авч үзвэл Улаанбаатар хот 49.3 хувь, Дархан-Уул аймаг 36.5 хувь, Орхон аймаг 34.4 хувь интернет хэрэглэж байгаа нь хамгийн дээгүүр үзүүлэлт бол Баян-Өлгий аймаг 7.9 хувь, Хөвсгөл аймаг 9.4 хувь, Архангай аймаг 9.6 хувь, Баянхонгор аймаг 9.8 хувь нь интернет хэрэглэж байгаа нь хамгийн доогуур үзүүлэлт байна. Бусад аймгийн хувьд б, түүнээс дээш настай нийт хүн амын 10.0 - 24.4 хувь интернет хэрэглэж байгаа нь улсын дунджаас доогуур үзүүлэлт юм.

ЗУРАГ 2.13. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ СУУРИН ХҮН АМД ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР



Интернетийн хэрэглээг бүсээр авч үзвэл Төвийн бүсийн аймгийн хүн амын 22.6 хувь интернет хэрэглэж байгаа нь хамгийн дээгүүр байхад Баруун бүсийн аймгийн 11.0 хувь байгаа нь хамгийн доогуур байна. Харин Зүүн бүсийн хүн амын 13.8 хувь, Хангайн бүсийн хүн амын 14.4 хувь интернет хэрэглэж байна. Үүнээс үзэхэд интернетийн хэрэглээ бүсүүдэд харилцан адилгүй байна.

ЗУРАГ 2.14. СУУРИН ХҮН АМЫН ТОО, ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭХ ТӨВШИН, БАЙРШЛААР



Зургаа, түүнээс дээш настай хүн амд интернет хэрэглэгчийн эзлэх хувийн жингээр нийслэл хамгийн өндөр 49.3 хувь, аймгийн төв 28.9 хувь, тосгонд 20.7 хувь байгааг дээрх зургаас харж болно. Энэ үзүүлэлт сумын төвд 11.1 хувь буюу улсын дунджаас 2 дахин, хөдөөд 3.6 хувь байгаа нь улсын дунджаас даруй 10 дахин бага байна. Аймгийн төвд амьдрагчийн интернет хэрэглэх төвшингөөр Дархан-Уул 41.6 хувь, Дорноговь аймаг 37.1 хувь, Төв аймаг 36.9 хувь, Орхон аймаг 35.9 хувь, Сэлэнгэ аймаг 32.9 хувь, Өмнөговь аймаг 32.5 хувь, Говь-Алтай аймаг 31.7 хувь нь интернет хэрэглэж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бол Баян-Өлгий аймаг 19.0 хувь, Увс аймаг 19.1 хувь, Хөвсгөл аймаг 19.4 хувь байгаа нь хамгийн доогуур үзүүлэлт болж байна. Бусад аймгийн хувьд ойролцоогоор хүн амын 25 орчим хувь интернет хэрэглэдэг ажээ.

Тосгонд амьдардаг хүн амын интернетийн хэрэглээ нэлээд ялгаатай байна. Тухайлбал, Дорноговь аймгийн тосгонд амьдрагчдын 28.6 хувь, Сэлэнгэ аймгийн тосгонд амьдрагчдын 22.7 хувь нь интернет хэрэглэж байхад Баянхонгор, Говь-Алтай аймгийн тосгонд амьдрагчдын 5.4 хувь нь интернет хэрэглэж байна.

Өмнөговь аймгийн сумын төвийн хүн амын 21.4 хувь, хөдөөгийн хүний 17.7 хувь интернет хэрэглэж байгаа нь бусад аймгийн сумын төв болон хөдөөгийн хүний интернет хэрэглэх төвшинтэй харьцуулахад өндөр байна. Энэ нь сүүлчийн жилүүдэд Оюу Толгой, Таван Толгой, Цогтцэций, Ухаа Худаг зэрэг газарт уул уурхайг түшиглэсэн эдийн засгийн төвлөрлийг дагаад МХХТ-ийн сүлжээг өргөнөөр оруулж байгаатай холбон үзэж болно.

Булган, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Хэнтий, Орхон, Говьсүмбэр аймгийн сумын төвд амьдрагчийн интернет хэрэглээ улсын дунджаас өндөр байна. Энэ нь тухайн аймагт уул уурхайг түшиглэсэн дэд бүтцийн асуудал олноор шийдвэрлэгдэж байгаа бас ОХУ, БНХАУ-ыг холбосон төмөр зам дагуу шилэн кабелийн төв сүлжээ байдагтай холбоотой.

2010 оны байдлаар нийслэл, аймгийн төв интернетийн сүлжээнд бүрэн, сум суурин газрын зарим нэг хэсэг хамрагдаад байна. Ийм үед интернетийн сүлжээ хараахан хүрээгүй хөдөө нутагт амьдарч буй 16.2 мянган интернет хэрэглэгчийн 3.2 хувь гэртээ байнга, 6.1 хувь бусад газар байнга, үлдэх 90.7 хувь нь шаардлагатай үед хэрэглэдэг гэсэн нь интернетийг



хэрхэн хаанаас хэрэглэдэг болох нь тодорхойгүй байна. Энэ нь магадгүй тухайн хүмүүс хот суурин газарт ирэх үедээ интернетийг ашигладаг эсвэл компьютер хэрэглэдгээ интернет хэрэглэдэг гэж үзээд хариулсан байх талтай. Сүлжээнд хамрагдаагүй газрын хүмүүсийн интернет хэрэглэдэг давтамжийг тодруулах, үнэхээр хэрэглэдэг эсэхийг лавлах, эсвэл сүүлчийн З сарын хугацаанд хэрэглэсэн эсэхийг бодитойгоор гаргах боломжтой.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод 2021 он гэхэд сум, суурин газрыг шилэн кабелийн болон бага оврын тоон радиорелейн сүлжээгээр холбож, төрийн болон арилжааны цахим үйлчилгээг хүлээн авах боломжийг хөдөөгийн хүн амын 70 хүртэл хувьд хүргэх зорилтыг тавьсан. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор хөдөөгийн хүний интернетийн хэрэглээ маш бага байгаагаас үзэхэд төр засгаас дорвitoй арга хэмжээ авч хөдөөгийн иргэний интернет хэрэглээг сайжруулахад анхаарах нь зүйтэйг харуулж байна.

2.3 БОЛОВСРОЛЫН ТӨВШИН

ОУХХБ-ын улс орны МХХТ-ийн хөгжлийн хүрсэн төвшинг тодорхойлоходоо тухайн орны хүн амын боловсролын төвшинтэй хамааруулж авч үздэг. Үүний нэгэн адилар тооллогын мэдээлэлд үндэслэн интернет, гар утасны хэрэглээг тухайн хэрэглэж буй хүний боловсролын төвшинтэй харьцуулан авч үзье. Тооллогоор 6, түүнээс дээш насны суурин хүн амын 86 хувьбуюу 1992.7 мянган боловсролтой⁶ хүн ам тоологдсон байна. Улс орны хүн амын боловсролын төвшин, бичиг үсгийн мэдлэгийн байдлыг 10, түүнээс дээш насны хүнээр тооцон гаргана. Гэхдээ нэгэнт гар утас, интернет хэрэглэдэг эсэхийг 6, түүнээс дээш насны хүн амаас асуусан учир боловсролын төвшингөөр ялган харуулахдаа 6, түүнээс дээш насны хүн амын хувьд үзүүлэлтийг ашигласан болно.


ЗУРАГ 2.15. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГЭЭР



2.3.1 ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧ

Боловсролтой хүн амын 81.5 хувь гар утас хэрэглэж байхад боловсролгүй хүний зөвхөн 28.1 хувь л гар утас хэрэглэж байна. Боловсролгүй хүний гар утасны хэрэглээ бага байгааг боловсрол эзэмшээгүй сургуульд сурч буй 6-9 насны 172.8 мянган хүн амтай холбон үзэж болох юм. Боловсролын төвшин ахих тусам гар утасны хэрэглээ нэмэгдэж байгааг Зураг 2.16-аас харна уу.

ЗУРАГ 2.16. НИЙТ ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХҮЙСЭЭР



⁶ Дээд, тусгай мэргэжлийн дунд, техник мэргэжлийн, бүрэн дунд, сурь, бага боловсрол



Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор 3591 докторын 97.6 хувь гар утас хэрэглэж байхад 2.4 хувь буюу 87 доктор гар утас хэрэглэдэггүй гэж хариулсан байна. Нийт гар утас хэрэглэж буй докторын зэрэгтэй хүмүүсийн 58.3 хувь эрэгтэй байна.


Магистр хамгаалсан хүмүүсийн 99 хувь нь гар утас хэрэглэж байгаа бол дээд боловсролтой хүмүүсийн 97.2 хувь, тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүмүүсийн 90.1 хувь хэрэглэж байна. Техник болон мэргэжлийн боловсролтой 6, түүнээс дээш настай хүний 82.5 хувь нь гар утас хэрэглэж байгаа нь бүрэн дунд болосролтой хүн амын гар утасны хэрэглээнээс 6.8 пунктээр бага байна. Энэ нь оюутан залуусын гар утасны хэрэглээ өндөр байдагтай холбоотой юм. Харин бага болон суурь боловсролтой гэж тоолуулсан хүн амын 50-иас илүү хувь гар утас хэрэглэж байна. Тооллогоор 322.9 мянган хүн боловсролгүй гэж бүртгүүлсний 82.4 хувь буюу 266.1 мянган хүн бичиг үсэг мэддэг бол үлдсэн 56.7 мянган хүн бичиг үсэг мэддэггүй аж. Боловсролгүй гэж бүртгүүлсэн мөртлөө бичиг үсэг мэддэг хүн амын 31.1 хувь, бичиг, үсэг мэддэггүй хүн амын 14.1 хувь гар утас хэрэглэж байна. Гар утасны хэрэглээг хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүдийнх эрэгтэйчүүдээс ерөнхийдөө дээгүүр, харин бичиг үсэг мэддэггүй эрэгтэй эмэгтэйчүүдийн хэрэглээнээс 2.7 пунктээр дээгүүр байна.

Боловсролын төвшин тухайн хүний хөдөлмөр эрхлэлтэй шууд хамаарлтай байдаг. Дээд боловсролтой хүний эдийн засгийн оролцооны төвшин боловсролын бусад төвшинтэй хүмүүстэй харьцуулахад өндөр байдаг ба түүнийг дагаад орлогын хэмжээ өндөр байх магадлалтай. Энэ утгаараа дээд боловсролтой хүний мэдээлэл харилцаа холбооны хэрэглээ өндөр байх ба энэ талаар эдийн засгийн идэвхийн байдалтай харьцуулан З дугаар бүлэгт дэлгэрэнгүй тайлбарлах болно.

2.3.2 ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧ

Гар утасны хэрэглээтэй харьцуулахад интернетийнх боловсролын төвшинтэй хүчтэй хамаарлтай байна. Интернет хэрэглэгчийг боловсролын төвшингөөр ангилж үзэхэд тооллогод хамрагдсан доктор болон магистрын зэрэгтэй хүний 90.4 хувь интернет хэрэглэдэг. Дипломын болон бакалаврын дээд боловсролтой хүн амын 70.1 хувь нь интернет хэрэглэж байна. Харин боловсролгүй хүний 7.6 хувь нь интернет хэрэглэдэг нь хамгийн бага үзүүлэлт болж байна. Бүрэн дунд боловсролтой хүн амын 34.5 хувь нь интернет хэрэглэж байгаа нь тусгай болон техник мэргэжлийн боловсролтой хүн амын интернетийн хэрэглээнээс дээгүүр байна. Энэ нь магадгүй бүх нийтийн мэдээлэл технологийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн материаллаг бааз, орчинг бүрдүүлэх зорилгоор 2007-2008 онд боловсролын салбарт “Хүүхэд бүрт компьютер”, зайн сургалтын “Цахим танхим” төсөл хэрэгжүүлсэнтэй холбоотой байж болох юм.

ЗУРАГ 2.17. НИЙТ ХҮН АМД ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХҮЙСЭЭР



Интернет хэрэглэдэг 6, түүнээс дээш настай нийт хүн амын 32.3 хувь гэртээ байнга, 20.3 хувь байнга бусад газар, 47.3 хувь шаардлагатай үед хэрэглэж байхад дээд боловсролтой интернет хэрэглэдэг хүний 56.6 хувь гэртээ, 26 хувь бусад газар байнга, 17.4 хувь шаардлагатай үед хэрэглэж байна. Харин докторын зэрэгтэй хүний 10 хувь (375 хүн), магистрын зэрэгтэй хүний 9.4 хувь (2991 хүн) нь интернетийг хэрэглэдэггүй байна.

Дипломын болон бакалаврын дээд боловсролтой интернет хэрэглэдэг хүн амын 36.9 хувь гэртээ, 24.7 хувь бусад газар, 38.3 хувь шаардлагатай үедээ интернетийг хэрэглэж байгаа бол дээрх боловсролтой хүн амын 30 хувь буюу 107.0 мянган хүн интернетийг хэрэглэдэггүй байна. Эндээс үзэхэд дээд боловсролтой хүмүүс интернетийг гажил амьдралдаа тогтмол, илүү өргөн хүрээгээр хэрэглэдэг гэж ойлгож болох юм. Боловсролын бусад төвшний интернет хэрэглэдэг хүн амын 50-иас илүү хувь шаардлагатай үед л интернетийг хэрэглэж байна.

Түүнчлэн бичиг үсэг мэддэггүй мөртөө интернет хэрэглэдэг 857 хүн байгаа нь сонирхол татаж байна. Эдгээр хүмүүс нь хэдийгээр бичиг үсэг мэддэггүй боловч тоглоом тоглох, кино үзэх зэрэгээр интернетийг хэрэглэдэг байж болох юм. Аль эсвэл тооллогоор алдаатай мэдээлэл авсан байх талтай. Мэдээллийг алдаатай гэж үзвэл дараа, дараагийн тооллогод мэдээлэл цуглуулалтын үед анхаарах нь зүйн хэрэг юм.

Боловсролын төвшин, МХХТ-ийн хэрэглээтэй шууд хамааралтай хэдий ч интернет, гар утсыг аль алиныг ашигладаггүй 8.3 мянган дээд боловсролтой хүн байна. Үүний 72 хувь буюу 5.9 мянган иргэн хотод⁷ түүний дотор 4.2 мянган нийслэлийн иргэн байна.

⁷ Улаанбаатар хот, аймгийн төв, тосгон


2.4 ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

2.4.1 ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧ

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулиар 18, түүнээс дээш насны хүн гэр бүл болох боломжтойг заасан байдаг боловч 2010 оны тооллогоор олон улсын аргачлал, зөвлөмжийн дагуу 15, түүнээс дээш насны хүн амаас гэр бүл болсон эсэх талаарх асуулгыг оруулсан.

Тооллогоор 15, түүнээс дээш настай 1905.9 мянган хүн байгаа бөгөөд 81.5 хувь буюу 1553.6 мянган иргэн гар утас хэрэглэж байна. Үүнийг гэр бүлийн байдлаар авч үзвэл гэр бүлээ баталгаажуулаагүй гэр бүлтэй хүн амын 86.2 хувь гар утас хэрэглэж байгаа нь хамгийн дээгүүр үзүүлэлт байна. Бэлбэсэрсэн хүн амын 64.7 хувь гар утас хэрэглэж байгаа нь хамгийн доогуур үзүүлэлт байна. Огт гэр бүл болоогүй, баталгаажуулсан гэр бүлтэй, тусгаарласан болон цуцалсан хүн амын 80-аас илүү хувь гар утас хэрэглэж байна.

**ЗУРАГ 2.18. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ,
ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР**



Дээрх зургаас харахад хотын нийт хүн амын дунд баталгаажуулсан гэр бүлтэй хүний 91.4 хувь гар утас хэрэглэж байгаа нь хамгийн дээгүүр бол харин хөдөөд баталгаажуулаагүй гэр бүлтэй хүн амын 67.2 хувь гар утас хэрэглэж байгаа нь хамгийн дээгүүр байна. Бэлбэсэрсэн хүн амын гар утасны хэрэглээ хот, хөдөөд хамгийн доогуур үзүүлэлттэй байна.


Гэр бүлийн байдлаар гар утасны хэрэглээг хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүдийнх их байна. Баталгаажуулсан гэр бүлтэй эрэгтэйчүүдийн гар утасны хэрэглээ эмэгтэйчүүдийнхээс 0.79 пункттээр дээгүүр байхад гэр бүлээ цуцалсан эмэгтэйчүүдийн гар утасны хэрэглээ эрэгтэйчүүдийнхээс 20.8 пункттээр дээгүүр байна.

2.4.2 ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧ

Тооллогоор 15, түүнээс дээш настай хүн амын 33.4 хувь буюу 636.0 мянган иргэн интернет хэрэглэж байна. Интернет хэрэглэгчийг гэр бүлийн байдлаар авч үзэхэд огт гэр бүл болоогүй хүмүүсийн 49.6 хувь интернет хэрэглэж байгаа нь хамгийн дээгүүр байна. Баталгаажуулаагүй гэр бүлтэй хүн амын 32.2 хувь интернет хэрэглэж байгаа нь улсын дунджаас ч дээгүүр байна. Энэ нь магадгүй гар утас хэрэглэгчийг бодвол интернет

хэрэглэгчид нь харьцангуй залуу хүмүүс байгаатай холбоотой байна. Харин бэлбэсрээн хүмүүсийн интернетийн хэрэглээ бусадтай харьцуулахад хамгийн бага байгаа нь тухайн бүлгийн хүмүүсийн дийлэнх хувь ахмад⁸ насны хүмүүс байдагтай холбоотой юм.

ЗУРАГ 2.19. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ, ГЭР БУЛИЙН БАЙДАЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР



Зургаас харахад хотын огт гэр бүл болоогүй хүн амын 62.4 хувь интернет хэрэглэж байгаа нь хамгийн өндөр бөгөөд хөдөөгийн огт гэр бүл болоогүй хүн амын хэрэглээнээс 49.1 пунктээр дээгүүр байна. Хотын хүн амын интернетийн хэрэглээ гэр бүлийн статус бүрт улсын дунджаас өндөр байна. Хотод интернетийн сүлжээ илүү их хамрагдсан байдагтай шууд холбоотой гэж үзэж болно.

ХҮСНЭГТ 2.1. ГАР УТАС, ИНТЕРНЕТИЙГ ХОЁУЛАНГ НЬ ХЭРЭГЛЭДЭГ БОЛОН ХЭРЭГЛЭДЭГГҮЙ ХҮН АМЫН ТОО, ГЭР БУЛИЙН БАЙДЛААР

| Гэрлэлтийн байдал | Интернет, гар утсыг хоёуланг нь хэрэглэдэг | | | Интернет, гар утсыг аль алийг нь ашигладаггүй | | |
|-------------------------|--|---------|---------|---|------------|------------|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| | | | | БҮХ ХҮН АМ | БҮХ ХҮН АМ | БҮХ ХҮН АМ |
| Огт гэр бүл болоогүй | 287 380 | 135 013 | 152 367 | 101 776 | 67 368 | 34 408 |
| Батлуулсан гэр бүлтэй | 258 847 | 118 182 | 140 665 | 169 086 | 82 187 | 86 899 |
| Батлуулаагүй гэр бүлтэй | 50 522 | 21 504 | 29 018 | 21 345 | 12 016 | 9 329 |
| Тусгаарласан | 6 288 | 1 802 | 4 486 | 4 382 | 3 012 | 1 370 |
| Цуцалсан | 10 405 | 2 782 | 7 623 | 6 524 | 4 533 | 1 991 |
| Бэлбэсэн | 10 066 | 1 230 | 8 836 | 36 683 | 8 692 | 27 991 |

⁸ Тэтгэврийн насны буюу 55-аас дээши насныхан

Тооллогоор зорилтод бүлгийн 1905.9 мянган хүний 32.7 хувь (623.5 мянган хүн) нь интернет, гар утсыг хослуулан хэрэглэж байгаа бол 17.8 хувь (339.7 мянган хүн) аль алийг нь огт хэрэглэдэггүй байна. Огт гэр бүл болоогүй хүн амын 48.2 хувь (287.3 мянган хүн) интернет, гар утсыг хоёуланг нь хэрэглэдэг байна. Энэ үзүүлэлт хот, хөдөөд ойролцоо төвшинд байна. Хотын бэлбэсэrsэн хүн амын 25.4 хувь, хөдөөгийн бэлбэсэrsэн хүн амын 54.3 хувь интернет, гар утсыг огт хэрэглэдэггүй байна. Хотын гэрлэсэн 10 хүн тутмын 3 нь интернет, гар утсыг хоёуланг нь хэрэглэж байгаа бол хөдөөд 10 хүн тутмын 3 нь интернет, гар утсыг хэрэглэдэггүй байна. Эндээс үзэхэд интернетийн хэрэглээ хот, хөдөөд ялгаатай байна гэж дүгнэж болно.

2.5 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

Хараа, яриа, сонсгол, хөдөлгөөн, сэтгэцийн ямар нэгэн согог, өвчин эмгэгийн улмаас харах, ярих, сонсох, биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх, сэтгэн бodoх хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан эдгээрийг хавсарсан эсвэл бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй тухайлбал, дотор эрхтний өвчин эмгэгтэй хүнийг тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй хэмээн авч үзсэн.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор Монгол орон даяар анх удаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тоолсон. Улсын хэмжээнд нийт 108.0 мянган хүн байгаагийн 98 хувь буюу 105.5 мянган хүн бүрдэхийн 6, түүнээс дээш настай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний интернет, гар утасны хэрэглээг дээрх насны хүн амын хувьд авч үзсэн гэдгийг дурдах нь зүйтэй.


Хөгжлийн бэрхшээлтэй иргэний 55.1 хувь буюу 58.2 мянган хүн гар утас хэрэглэж байна. Нийт гар утас хэрэглэгчийн 3.4 хувь нь ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй байна гэсэн үг.

ЗУРАГ 2.20. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭСЭХЭЭР



Хөгжлийн бэрхшээлтэй иргэний 55.2 хувь буюу 58.3 мянга нь эрэгтэй хүн байна. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хүйсийн харьцаа ерөнхийдөө ойролцоо байгаа бол олдмол бэрхшээлтэй хүн амын 57.6 хувь нь эрэгтэй хүн байна. Ажил амьдралынх нь хэв маяг, хүнд хүчир ажлыг эрэгтэйчүүд түлхүү хийдгээс хамаараад эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүд хөгжлийн бэрхшээлтэй болох нь илүү байдаг байна. Тэгвэл эдгээр иргэний гар утасны хэрэглээг хүйсээр болон бэрхшээлийн хэлбэрээр ялган авч үзье.

ЗУРАГ 2.21. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ХҮЙС, ХУВИАР



Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 34.9 мянган хүний 40.7 хувь буюу 14.2 мянган хүн гар утас хэрэглэж байхад харин олдмол бэрхшээлтэй хүн амын 62.3 хувь буюу 43.9 мянган хүн гар утас хэрэглэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний гар утасны хэрэглээг бэрхшээлийн хэлбэрээр авч үзэхэд ярианы болон сэтгэцийн бэрхшээлтэй иргэний гар утасны хэрэглээ хамгийн доогуур бол харааны, сонсгол, хөдөлгөөний болон бусад бэрхшээлтэй иргэний 50-иас илүү хувь гар утас хэрэглэж байна.

Аймаг, нийслэлээр хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь гар утасны хэрэглээг авч үзвэл Улаанбаатар хотын төрөлхийн бэршээлтэй иргэний 56.5 хувь гар утас хэрэглэж байгаа нь хамгийн дээгүүр бол Баян-Өлгий аймгийн 22.2 хувь гар утас хэрэглэж байгаа нь хамгийн доогуур үзүүлэлт болж байна. Орхон аймгийн олдмол бэрхшээлтэй иргэний 75.2 хувь гар утас хэрэглэдэг нь бусад аймагтай харьцуулахад өндөр бол Баян-Өлгий аймгийн 31.4 хувь гар утас хэрэглэж байгаа нь хамгийн бага байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний бэрхшээлийн хэлбэрээр аймаг, нийслэлийн төвшинд авч үзэхэд ялгаатай байна. Тухайлбал, Хөвсгөл, Дорноговь аймгийн харааны бэрхшээлтэй иргэний, Баянхонгор, Говьсүмбэр аймгийн хөдөлгөөний бэрхшээлтэй иргэний гар утасны хэрэглээ өндөр байхад бусад аймгийн яриа, хөдөлгөөний болон бусад төрлийн бэрхшээлтэй иргэний гар утасны хэрэглээ хамгийн их байна.

ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ


Тооллогод хамрагдсан зургаа, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлгүй хүн амын 31.6 хувь буюу 698.7 мянган хүн интернетийг ямар нэгэн байдлаар хэрэглэж байхад бэрхшээлтэй хүн амын 10.3 хувь буюу 10.8 мянган хүн интернет хэрэглэж байна. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэний интернетийн хэрэглээ нь хөгжлийн бэрхшээлгүй иргэний интернетийн хэрэглээнээс 21.3 пунктээр доогуур байна. Интернет хэрэглэдэг хүн амын 1.5 хувь нь ямар нэгэн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний интернетийн хэрэглээг хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүдийнх эрэгтэйчүүдийнхээс өндөр байна.

Зургаа, түүнээс дээш настай төрөлхийн бэрхшээлтэй хүн амын 8.6 хувь буюу 2.9 мянган иргэн, олдмол бэрхшээлтэй хүн амын 11.1 хувь буюу 7.8 мянган хүн интернет хэрэглэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний интернетийн хэрэглээг бэрхшээлийн хэлбэрээр авч үзвэл харааны бэрхшээлтэй хүн амын 14.2 хувь, сэтгэцийн бэрхшээлтэй болон ярианы

бэрхшээлтэй хүн амын 4 хувь интернет хэрэглэж байна. Бусад хэлбэрийн бэрхшээлтэй хүн амын 11 орчим хувь нь интернет хэрэглэж байна. Эндээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй 10 хүн тутмын 1 нь интернет хэрэглэдэг гэсэн үг юм.

ЗУРАГ 2.22. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ХҮЙС, ХУВИАР



Хөгжлийн бэрхшээлтэй иргэний интернет хэрэглэдэг хэлбэрийг хот, хөдөөгөөр ангилан авч үзвэл төрөлхийн болон олдмол бэрхшээлтэй хотын хүн амын 36.2 хувь (3.6 мянган хүн) интернетийг байнга гэртээ, 16.8 хувь (1.6 мянган хүн) интернетийг бусад газар байнга хэрэглэж байгаа бол 46.9 хувь шаардлагатай үед хэрэглэж байна. Харин хөдөөгийн дээрх хүн амын хувьд 12.1 хувь (108 хүн) байнга гэртээ, 16.5 хувь (147 хүн) бусад газар байнга, 71.4 хувь шаардлагатай үед хэрэглэдэг гэж хариулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний 9.5 хувь буюу 10.0 мянган хүн гар утас, интернетийг зэрэг ашиглаж байна. 44.1 хувь буюу 46.5 мянган хүн аль алийг хэрэглэдэггүй ажээ.


2.6 ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭНИЙ ГАР УТАС, ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ

Монгол Улсад байнга (6, түүнээс дээш сар) оршин суугаа 16.3 мянган гадаадын харьяат иргэний 53.2 хувь БНХАУ, 15.2 хувь ОХУ, 9.3 хувь БНСҮ, 4 хувь АНУ-ын иргэн байна. Тэдгээрийн 74 хувь эрэгтэй, 82.4 хувь 15-54 насны хүн байна.


Гадаадын харьяат 6, түүнээс дээш настай 15.7 мянган иргэн байна. Эдгээр иргэний интернет хэрэглээний төвшин 58.1 хувь байгаа улсын дундухаас 27.5 пунктээр, гар утасны хэрэглээний төвшин 83.3 хувь байгаа нь улсын дундухаас 9.3 пунктээр дээгүүр байна. Өөрөөр хэлбэл, гадаадын харьяат 10 хүн тутмын 6 нь интернет, 8 нь гар утас, 5 нь хоёуланг нь хэрэглэдэг бол 10 хүн тутмын 1 нь аль алийг нь хэрэглэдэггүй гэсэн байна. Интернет, гар утсыг хэрэглэдэггүй 2023 гадаадын харьяат иргэн байгаа бөгөөд 82 хувь буюу Хойд Солонгос (423 иргэн), БНХАУ (1245 иргэн)-ын иргэн байна.

Гадаадын харьяат иргэний интернетийн хэрэглээг улс орноор ялган үзэхэд Хойд Солонгос, БНХАУ, мөн гар утасны хэрэглээг үзэхэд Хойд Солонгос улсын харьяат иргэний хэрэглээ хамгийн доогуур байна.

ЗУРАГ 2.23. ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭНИЙ ТОО, ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ, УЛС ОРНООР



ЗУРАГ 2.24. ГАДААДЫН ХАРЬЯАТ ИРГЭНИЙ ТОО, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, УЛС ОРНООР



Дээрх зургаас харахад гадаадын харьяат иргэний интернет, гар утасны хэрэглээний төвшин өндөр байна.

ГУРАВЛУГААР БҮЛЭГ

ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ БА ӨРХИЙН ГАР УТАС,
ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ



3.1 ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор олон улсын стандартын дагуу 15, түүнээс дээш насны хүн амд хөдөлмөр эрхлэх байдлын талаарх асуулгыг явуулсан билээ. Тооллогын товын өмнөх 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ядаж нэг цаг ажил хийсэн 911.6 мянган хөдөлмөр эрхэлдэг хүн байв. Харин хөдөлмөр эрхлэхгүй байгаа 994.3 мянган хүн байна.

Энэ бүлэгт арван тав, түүнээс дээш настай хүн амын эдийн засгийн идэвх, түүний дотор ажил эрхэлдэг, ажил хайж буй хүн ам, эдийн засгийн идэвхгүй хүн амын гар утас, интернетийн хэрэглээний талаар нарийвчлан үзье. Түүнчлэн хөдөлмөр эрхэлдэг хүн амын ажилладаг салбар, мэргэжил болон ажил мэргэжлийн байдлаар гар утас, интернетийн хэрэглээ хэр зэрэг ялгаатай байгааг тодруулсан болно.

3.1.1 ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧ

Хөдөлмөрийн насны 1906.0 мянган хүн ам байгаагийн 81.5 хувь гар утас хэрэглэж байна. Энэ нь 6, түүнээс дээш настай нийт хүн амын гар утасны хэрэглээний төвшин (74.0 хувь)-ээс 5.5 пунктээр дээгүүр байна. Энэ нь 6-14 насны хүүхдийн гар утасны хэрэглээ бага байдагтай холбоотой болов уу. Тооллогын өмнөх 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд нэгээс дээш цагаар оролцсон буюу ажил эрхэлж буй иргэний гар утасны хэрэглээний төвшин бусад бүлгийнхтэй харьцуулахад өндөр байгааг Зураг 3.4-өөс харна уу. Эдийн засгийн идэвхтэй хүн амын гар утасны хэрэглээг аймаг, нийслэлээр авч үзэхэд Дорноговь, Дорнод, Дундговь, Сэлэнгэ, Хэнтий, Дархан-Уул, Улаанбаатар, Орхон, Говьсүмбэрт улсын дунджийн нэгэн адилаар хамгийн өндөр байна. Харин бусад 13 аймгийн хувьд ажил хайж буй хүн амын гар утасны хэрэглээ өндөр байна.


ЗУРАГ 3.4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭР



Гар утас хэрэглэгчийг эдийн засгийн идэвх ба боловсролын төвшингөөр ангилж үзэхэд нэлээд ялгаатай талууд ажиглагдаж байна. Тухайлбал, боловсролтой хөдөлмөр эрхэлдэг хүн амд гар утас хэрэглэгчийн эзлэх хувийн жин бусад бүлэгтэй харьцуулахад дээгүүр байхад харин бүрэн дунд, суурь боловсролтой эдийн засгийн идэвхгүй хүн амын дунд гар утасны хэрэглээ өндөр байгааг Зураг 3.5-аас харж болно. Энэ нь бүрэн дунд болон суурь


боловсролтой эдийн засгийн идэвхгүй хүн амын тал хувийг эзэлдэг сургуульд сурдаг оюутан, сурагчдын гар утасны хэрэглээний төвшин өндөр байдагтай холбоотой юм. Боловсролгүй болон бага боловсролтой ажилгүй хүн амын гар утасны хэрэглээ бусдаасаа өндөр байна. Харин бүрэн дунд, суурь боловсролын төвшингөөс бусад төвшинд эдийн засгийн идэвхгүй хүн амын гар утасны хэрэглээ хамгийн доогуур байна.

ЗУРАГ 3.5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИНГӨӨР




Ажил эрхэлдэг хүн амын 84.4 хувь нь гар утас хэрэглэж байна. Хөдөлмөр эрхэлдэг хүн амын гар утасны хэрэглээг авч үзэхэд ажил олгогчийн 96.8 хувь, цалин хөлстэй ажиллагчийн 93.9 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн 79.6 хувь, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчийн 51.7 хувь гар утас хэрэглэж байна.

ЗУРАГ 3.6. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛААР



Хөдөлмөр эрхэлдэг хүн амын гар утасны хэрэглээний төвшинг эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрхэлдэг ажлаар ангилж үзье. Тооллогоор хөдөлмөр эрхэлдэг 911.6 мянган хүн бүртгэгдсэний 26.4 хувь буюу 241.0 мянган хүн ХАА, ан агуур, ойн аж ахуй, загас барих зэрэг салбарт ажилладаг аж. Энэ салбарт ажиллаж буй нийт хүн амын 56 хүн гар утас хэрэглэж байгаа нь хамгийн доогуур үзүүлэлт бол санхүү болон даатгалын салбарт ажиллаж буй хүн амын 98.7 хувь нь гар утас хэрэглэж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

ЗУРАГ 3.7. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ ТӨВШИН, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛЭР



Хөдөлмөр эрхэлдэг хүн амын гар утасны хэрэглээг ажил мэргэжлээр авч үзэхэд 100 менежер тутмын 98.9 нь гар утас хэрэглэж байгаа нь хамгийн дээгүүр үзүүлэлт байлаа. Харин ХАА, ой, загас, агуурын мэргэшсэн 100 ажилтан тутмын 56 нь гар утас хэрэглэж байгаа нь хамгийн бага бол дараа нь зэвсэгт хүчиний ажил, мэргэжилтний хэрэглээ (100 хүнд 65) орж байна. Хөдөлмөр эрхлэдэг хүн амын гар утасны хэрэглээг аймгийн төвшинд авч үзэхэд Баян-Өлгий, Булган, Дорноговь, Дорнод, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Орхон аймаг, Улаанбаатар хотын ХАА, ой, загас, агуурын мэргэшсэн ажилтны гар утасны хэрэглээний төвшин бусад бүлэгтэй харьцуулахад хамгийн доогуур бол бусад 12 аймагт зэвсэгт хүчиний ажил, мэргэжилтний гар утасны хэрэглээ хамгийн доогуур байна.

ЗУРАГ 3.8. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, ЭРХЭЛДЭГ АЖИЛ МЭРГЭЖИЛ, ХУВИАР




Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт малчид гар утас ашиглах, харилцаа холбоогоор шуурхай хангагдах нөхцлийг бүрдүүлнэ гэж заасан байдаг. ХАА, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан бүлэгт харьяалагдаж буй хүн амаар малчдыг төлөөлүүлж ойлговол тус салбарт ажиллаж буй ажиллагсдын 50 хувь нь гар утас хэрэглэж байна. Гар утас хэрэглэгчийн эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрхэлдэг ажлын ялгаатай байдлыг арилгахын тулд төр засгаас дорвitoй арга хэмжээ авч улмаар малчдыг мэдээлэл харилцаа холбоогоор шуурхай хангагдах нөхцлийг сайжруулах хэрэгтэй болох нь дээрх мэдээллээс харагдаж байна.

Тооллогын өмнөх 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй боловч хэрэв ажил олдвол хийхэд бэлэн байгаа 164.1 мянган ажил хайж буй хүн амын 82.4 хувь буюу 135.2 мянга хүн гар утас хэрэглэж байна. Сүүлчийн жилүүдэд их, дээд сургуулийн тоо олширч ерөнхий боловсролын сургууль төгссөн хүн бүр дээд боловсрол эзэмшихээр хот, суурин газрыг зорих болжээ. Хэдийгээр дээд боловсрол эзэмшсэнээр тухайн хүний хөдөлмөр эрхлэх боломж сайжрах боловч хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн зөрүүгээс үүдэлтэй дээд боловсролтой ажилгүй иргэний тоо 28.4 мянгад хүрчээ. Тэдний 96.7 хувь нь буюу 27.5 мянган хүн гар утас хэрэглэж байна.

Хөдөлмөр эрхлэх чадвартай хэдий ч сургуульд сурдаг, гэрийн ажилтай, ажиллах сонирхолгүй, тэтгэвэрт суугаа болон бусад шалтгааны улмаас хөдөлмөр эрхэлдэггүй хөдөлмөр эрхлэх чадваргүй 15 болон түүнээс дээш насны хүн амыг эдийн засгийн идэвхгүй хүнд хамааруулж авч үзэв.

Эдийн засгийн идэвхгүй хүн амын 78.2 хувь нь гар утас хэрэглэж байна. Үүнийг хөдөлмөр эрхлэхгүй шалгаанаар ангилж тэдний гар утасны хэрэглээг авч үзэхэд сургуульд сурдаг хүн амын 90.6 хувь, гэрийн ажилтай хүн амын 82.7 хувь, тохирох ажил олдохгүй буйн улмаас хөдөлмөр эрхлэхгүй байгаа хүн амын 78.4 хувь гар утас хэрэглэж байна. Уг үзүүлэлтийг аймгийн төвшинд авч үзэхэд улсын хэмжээнд эдийн засгийн идэвхгүй хүн амын дотор сургуульд сурдаг хүний гар утасны хэрэглээ хамгийн өндөр байхад Өмнөговь аймагт гэрийн ажилтай, Баян-Өлгий аймагт тохирох ажил олдохгүй шалтгааны улмаас хөдөлмөр эрхлэхгүй буй хүн амын гар утасны хэрэглээ хамгийн өндөр байна.


ЗУРАГ 3.9. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН, ХУВИАР



3.1.2 ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧ


Эдийн засгийн идэвхгүй 830.2 мянган хүний 35 хувь ямар нэгэн байдлаар интернет хэрэглэж байгаа нь бусад бүлэгтэй харьцуулахад өндөр төдийгүй эдийн засгийн идэвхтэй хүн амын интернетийн хэрэглээнэс 2.7 хувиар өндөр байна. Энэ нь эдийн засгийн идэвхгүй бүлэгт хамаардаг 15, түүнээс дээш насын оюутан, сурагчдын интернетийн хэрэглээ өндөр байдагтай холбоотой юм. Энэхүү үзүүлэлтийг аймгаар авч үзэхэд Архангай, Булган, Говь-Алтай, Дорнговь, Дундговь, Өвөрхангай, Төв, Ховд, Хөвсгөл, Дархан-Уул зэрэг 10 аймгийн эдийн засгийн идэвхгүй хүн амын интернетийн хэрэглээ бусад бүлэгтэй харьцуулахад өндөр байхад үлдсэн 11 аймаг болон нийслэлд ажил эрхэлдэг нийт хүн амын интернетийн хэрэглээ хамгийн дээгүүр үзүүлэлт болж байна. Гэтэл Баян-Өлгий аймгийн эдийн засгийн идэвхгүй хүн амын интернетийн хэрэглээ бусадтай харьцуулахад хамгийн доогуур байна.

ЗУРАГ 3.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭР




Арван тав, түүнээс дээш настай хүн амын боловсролын төвшин ба эдийн засгийн идэвхийн үзүүлэлтээр ангилж интернетийн хэрэглээг үзэхэд бага, суурь, бүрэн дунд боловсролтой эдийн засгийн идэвхгүй хүн амын хэрэглээ бусад бүлэгтэй харьцуулахад нэлээд өндөр байна.

ЗУРАГ 3.11. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИНГӨӨР



Арван тав, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн амын интернет хэрэглэгчийн эзлэх хувийн жинг ажил эрхлэлтийн байдлаар авч үзэхэд ажил олгогчийн 71.9 хувь, цалин хөлстэй ажиллагчийн 46.8 хувь нь интернет хэрэглэж байгаа нь хөдөлмөр эрхэлдэг хүний интернет хэрэглээний дунджаас өндөр байна. Харин өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчдын интернетийн хэрэглээ ердөө 3.6 хувь байгаа нь хэрэглээний ялгаа өндөр байгааг харуулж байна.

ЗУРАГ 3.12. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР



Ажил эрхэлдэг хүн амын интернетийн хэрэглээг эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлээр ялган үзэхэд олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн газар ажиллаж буй хүний интернетийн хэрэглээ (100 хүнд 81) бусад салбарт ажиллагсдаас өндөр байна. Гэтэл ХАА, ан агнуур, ойн аж ахуйн, загас барих салбарт ажиллагсдын зөвхөн 1.5 хувь нь интернетийн хэрэглэж байна. Улаанбаатар хотын тухайн салбарт ажилладаг хүн амын 24.1 хувь интернет хэрэглэдгээс үзэхэд интернетийн хэрэглээ нь хүн амын оршин суугаа газар буюу байршилаас ихээхэн хамааралтайг харж болно. Өөрөөр хэлбэл, тухайн хүний ажлын байр, гэр интернетийн холболттой эсэхээс шууд хамааралтай гэсэн үг юм.


ЗУРАГ 3.13. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ТӨВШИН, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛЭР



Түүнчлэн олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн газарт ажиллаж буй хүний 80.2, мэдээлэл холбооны салбарт ажиллаж буй хүний 78.3 интернет, гар утсыг хослуулан хэрэглэж байгаа нь салбарын дунджаас 2.3 дахин их байв.

Ажил эрхэлдэг хүн амын интернетийн хэрэглээг эрхэлдэг ажил мэргэжлээр нь авч үзэхэд 100 менежер хүн тутмын 76 нь интернет хэрэглэж байгаа нь бусад бүлэгтэй харьцуулахад өндөр; мэргэжилтэн, контор үйлчилгээний ажилтны хэрэглээ дараа нь орж байна. Гэтэл ХАА, ой загас агнуурын мэргэшсэн ажилтны интернет хэрэглээний төвшин хамгийн бага (0.9 хувь) байна.


ЗУРАГ 3.14. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ТӨВШИН, ЭРХЭЛДЭГ АЖИЛ МЭРГЭЖЛЭЭР



Манай улсын 164.1 мянган ажилгүй хүний 22.2 хувь буюу 36.4 мянган хүн интернет хэрэглэж байна. Аймаг, нийслэлийн ажилгүй хүн амын интернет хэрэглэх төвшинг авч үзэхэд Улаанбаатар, Орхон, Дархан-Уул аймаг хамгийн дээгүүр; дараа нь Дорноговь, Өмнөговь аймаг орж байна. Харин эсрэгээр Завхан аймгийн ажилгүй хүн амын интернет хэрэглээ хамгийн бага, дараа нь Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Баян-Өлгий, Увс, Говь-Алтай аймгийн ажилгүй хүн амын 10 хүрэхгүй хувь интернет хэрэглэж байна. Дээд боловсролтой ажилгүй хүн амын 63.5 хувь буюу 28.1 мянган хүн интернет хэрэглэдэг ажээ.

Арван тав, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй 830.2 мянган хүний интернет хэрэглээг хөдөлмөр эрхлэхгүй буй шалтгаанаар ангилж үзэхэд нэлээд ялгаатай байдал ажиглагдаж байна. Тухайлбал, эдийн засгийн идэвхгүй хүн амын 36.2 хувь сургуульд сурдаг байхад интернет хэрэглэдэг эдийн засгийн идэвхгүй хүн амын 72.1 хувь нь сургуульд сурч байгаа нь нэлээд өндөр үзүүлэлт юм. Түүнчлэн эдийн засгийн идэвхгүй хүн амын 35 хувь (290.0 мянган хүн) нь интернет хэрэглэж байгаагийн дотор сургуульд сурдаг хүн амын 69.5 хувь нь интернет хэрэглэж байгаа нь бусад шалтгааны улмаас хөдөлмөр эрхлэхгүй буй хүн амын хэрэглээнээс маш их ялгаатай байна. Сургуульд сурдаг хүмүүсийн интернетийн өндөр хэрэглээг хасч эдийн засгийн идэвхгүй хүн амын интернетийн хэрэглээг тооцвол 15.3 хувь гарч байгаа ба эндээс сургуульд сурдаг хүний интернетийн хэрэглээ дунджид их нөлөөлж байгаа нь харагдаж байна.

ЗУРАГ 3.15. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААНААР



3.2 ӨРХИЙН ИНТЕРНЕТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

3.2.1 ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

Монгол Улсын Засгийн Газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг өрх бүрт хүртээмжтэй болгоно гэж заасан.

2010 оны байдлаар Монгол Улсын 713.9 мянган өрхийн 91.5 хувь буюу 653.4 мянган өрхийн нэг болон түүнээс гишүүн гар утас хэрэглэж байна. Үлдсэн 8.5 хувь буюу 60.3 мянган өрхөд гар утас хэрэглэдэг гишүүн байхгүй байгаа бөгөөд цаашид үүгээр гар утасгүй өрхийн тоог тодорхойлон авч үзье.

Манай улс өргөн уудам газар нутагтай, цөөхөн хүн амтай, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг, малын бэлчээр даган нүүдэллэж аж төрсөөр ирсэн уламжлалтай билээ. Гэхдээ мэдлэгт тулгуурласан XXI зууны өнөөгийн нийгэмд амьдарч буй хүн бүр биш гэхэд өрх бүр ядаж дундаа нэг гар утас хэрэглэх нь амьдралын зайлшгүй хэрэглээний нэг гэж үзэж болно. Гэтэл дээрх статистик нь хангалтгүй, энэхүү нөхцөл байдлыг сайжруулахын тулд төр засгаас дорвитой арга хэмжээ авах нь зүйтэй. Үүний тулд жишиг нь, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтайгаар хүн амын нягтрал багатай газарт гар утасны сүлжээний дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, эсвэл энэхүү ажлыг оператор компанийн нийгмийн хариуцлагат ажилд тусгаж өгч болох юм.

Гар утасгүй өрхийг байршилаар авч үзэхэд хотод 15.5 мянган өрх буюу хотын өрхийн 3.2 хувь, хөдөөд 44.9 мянган өрх буюу хөдөөгийн өрхийн 19.2 хувийг эзэлж байна. Үүнийг хүн ам цөөтэй хөдөө нутагт гар утасны үйлчилгээ үзүүлэгч оператор компанийн сүлжээ бүрэн хүрч чадаагүйтэй холбон тайлбарлаж болно.


Манай улсын нэг өрхийн ам булийн дундаж тоо 3-4 байдаг. Харин дээрх гар утасгүй өрхийн 38.4 хувь нэг ам бүлтэй, 37.6 хувь 2-3 ам бүлтэй, 24.0 хувь 3 болон түүнээс дээш ам бүлтэй өрх байна. Эндээс үзэхэд гар утасгүй өрх харьцангуй цөөн ам бүлтэй байна гэж үзэж болно.

ХҮСНЭГТ 3.5. НИЙТ ӨРХӨД ГАР УТАСГҮЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, БАЙРШЛААР

| Аймаг, нийслэл | Бүгд | | Хот | | Хөдөө | |
|-------------------|---------------|----------------------------|---------------|----------------------------|---------------|----------------------------|
| | Өрхийн тоо | Гар утасгүй өрхийн хувь | Өрхийн тоо | Гар утасгүй өрхийн хувь | Өрхийн тоо | Гар утасгүй өрхийн хувь |
| БҮГД | 60 344 | 8.5 | 15 455 | 3.2 | 44 889 | 19.2 |
| Баян-Өлгий | 6 141 | 31.9 | 611 | 8.6 | 5 530 | 45.5 |
| Архангай | 5 894 | 24.0 | 415 | 7.2 | 5 479 | 29.2 |
| Сүхбаатар | 2 891 | 20.4 | 345 | 7.9 | 2 546 | 26.0 |
| Хөвсгөл | 6 672 | 20.2 | 971 | 8.5 | 5 701 | 26.4 |
| Завхан | 2 921 | 15.7 | 262 | 5.4 | 2 659 | 19.4 |
| Баянхонгор | 3 373 | 15.5 | 581 | 6.9 | 2 792 | 21.0 |
| Өвөрхангалай | 3 934 | 14.0 | 608 | 5.7 | 3 326 | 19.1 |
| Увс | 2 556 | 13.7 | 489 | 7.0 | 2 067 | 17.8 |
| Ховд | 2 588 | 13.7 | 346 | 4.9 | 2 242 | 18.8 |
| Булган | 2 139 | 13.5 | 313 | 7.4 | 1 826 | 15.8 |
| Говь-Алтай | 1 930 | 13.3 | 415 | 8.6 | 1 515 | 15.6 |
| Хэнтий | 2 432 | 12.7 | 703 | 8.0 | 1 729 | 16.6 |
| Дорнод | 1 969 | 10.4 | 631 | 6.0 | 1 338 | 15.9 |

| | | | | | | |
|-------------|-------|-----|-------|-----|-------|------|
| Төв | 2 420 | 9.8 | 176 | 4.6 | 2 244 | 10.7 |
| Дундговь | 988 | 9.1 | 244 | 6.4 | 744 | 10.5 |
| Дорнговь | 1 330 | 8.0 | 321 | 3.4 | 1 009 | 14.4 |
| Өмнөговь | 1 088 | 7.3 | 202 | 3.6 | 886 | 9.5 |
| Сэлэнгэ | 1 631 | 6.1 | 712 | 5.3 | 919 | 6.8 |
| Говьсүмбэр | 205 | 5.3 | 149 | 5.3 | 56 | 5.6 |
| Дархан-Уул | 744 | 3.1 | 513 | 2.6 | 231 | 5.5 |
| Орхон | 620 | 2.6 | 570 | 2.4 | 50 | 6.1 |
| Улаанбаатар | 5 878 | 1.9 | 5 878 | 1.9 | | |

ЗУРАГ 3.16.НИЙТ ӨРХӨД ГАР УТАСГҮЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМАГ НИЙСЛЭЛЭР




Аймаг, нийслэлийн төвшинд гар утас хэрэглэдэггүй өрхийн тоогоор авч үзэхэд Баян-Өлгий аймгийн өрхийн 31.9 хувь, Архангай аймгийн өрхийн 24.0 хувь гар утас хэрэглэдэггүй өрх байгаа нь хамгийн өндөр бол дараа нь Сүхбаатар, Хөвсгөл аймгийн өрхийн 20 хувь гар утас хэрэлдэггүй байна. Харин Улаанбаатар хотын нийт өрхийн 1.9 хувийг гар утас хэрэглэдэггүй өрх эзэлж байгаа нь хамгийн бага, дараа нь Орхон, Дархан-Уул аймгийн өрхийн 3 орчим хувь нь гар утас хэрэглэдэггүй байна. Бусад аймгийн хувьд нийт өрхийн 5.3-15.7 хувь нь гар утас огт хэрэглэдэггүй ажээ. Эндээс үзэхэд 6, түүнээс дээш настай хүний гар утасны хэрэглээ харьцангуй өндөр байгаа хэдий ч өрхийн гар утасны хэрэглээ хангалтгүй төвшинд байна гэж хэлж болохоор байна.

3.2.2 ӨРХИЙН ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ

Олон улсын МХХТ-ийн хөгжлийн хүрсэн төвшинг илэрхийлдэг нэг гол үзүүлэлт бол интернет холболттой өрхийн тоо юм. Гэртээ интернет байнга хэрэглэдэг нэг болон түүнээс дээш гишүүнтэй өрхийн тоогоор интернет холболттой өрхийн тоог гарган авч үзье. Ингэхэд, манай улсын нийт өрхийн зөвхөн 12.3 хувь (87.7 мянган өрх) интернет холболттой гэсэн үзүүлэлт гарч байна. Үүнийг хот, хөдөөгөөр авч үзвэл хотын өрхийн 17.9 хувь (85.9 мянган өрх) интернет холболттой бол харин хөдөөгийн өрхийн 0.7 хувь (1.7 мянган өрх) интернет холболттой байна. Үүнийг нийслэлээс алслагдсан, хүн амын нягтрал багатай хөдөө орон нутагт интернетийн дэд бүтэц хүрч чадаагүйтэй холбон тайлбарлаж болох юм. ОУХХБ-аас гаргасан мэдээллээс үзэхэд Азийн орнуудын хувьд 100 өрх тутмын 17⁹ интернет холболттой байдаг нь манай улсын дунджаас 4.5 пунктээр өндөр байна.

**ЗУРАГ 3.17. НИЙТ ӨРХӨД ИНТЕРНЕТ ХОЛБОЛТТОЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИН,
АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР**



Интернет холболттой өрхийн тоог аймаг, нийслэлээр авч үзэхэд нэлээд ялгаатай байна. Тухайлбал, Улаанбаатар хотын нийт өрхийн 23.9 хувь буюу 72.3 мянган өрх интернет холболттой байгаа нь хамгийн дээгүүр үзүүлэлт төдийгүй улсын дунджаас нэг дахин их байна. Түүний дараагаар Орхон аймгийн нийт өрхийн 13.9 хувь (3.3 мянган өрх), Дархан-Уул аймгийн нийт өрхийн 11 хувь (2.6 мянган өрх) интернет холболттой байгаа нь дээгүүр үзүүлэлт болж байна. Харин эсрэгээр Архангай аймгийн өрхийн 1.2 хувь (297 өрх) интернет холболттой байгаа нь хамгийн бага үзүүлэлт бол дараа нь Өвөрхангай, Хөвсгөл, Сүхбаатар, Булган, Завхан аймгийн өрхийн 2 хүрэхгүй хувь интернет холболттой байна. Интернет холболттой өрхийн тоо нь тухайн бүс нутаг, аймаг нийслэлийн нийт өрхийн хэдэн хувь нь төв, суурин газарт амьдардаг, тэр дундаа байшинд амьдардаг болохоос ихээхэн хамааралтай юм.

9 ITU World Telecommunication/ICT Indicators database- <http://www.itu.int/ITU-D/ict/definitions/regions/index.html> 2011.11.11-ний мэдээллээс авав.


3.3 ОРОН СУУЦНЫ ЯЛГААТАЙ БАЙДАЛ

3.3.1 ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүн ам олноор суурьшсан газарт гар утасны сүлжээг оруулснаар тухайн бус нутгийн ард иргэд түүнийг өргөнөөр хэрэглэх нөхцөл бололцоо бүрддэг. 2005-2011 онд Дэлхийн банк, Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах төсөл хэрэгжүүлснээр Улаанбаатар хотоос алслагдсан аймаг, сумын хүн ам гар утас ашиглах боломж бүрдсэн.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор улсын хэмжээнд 713 780 өрхийн 45.2 хувь гэрт, 1.1 хувь бусад сууцанд, 53.6 хувь барилга байшинд амьдарч байна. Барилга байшинд амьдардаг өрхийн 37.7 хувь орон сууцны байшин, 1.0 хувь бие даасан тохилог сууцад, 55.3 хувь сууцны тусдаа байрт амьдардаг. Хүн амыг сууцны төрлөөр ангилж үзэхэд суурин хүн амын 43.6 хувь буюу 1153.0 мянган хүн гэрт, 2.5 хувь буюу 64.9 мянган хүн бусад сууцад, 54.0 хувь буюу 1429.6 мянган хүн барилга байшинд амьдарч байна.

ЗУРАГ 3.18. ӨРХИЙН ТОО, ОРОН СУУЦНЫ ТӨРЛӨӨР



Гар утас хэрэглэдэг хүн амын 36.6 хувь гэрт, 2.3 хувь бусад сууцад, 61.1 хувь барилга байшинд амьдардаг гэж хариулсан байна. Харин хүн амын дунд гар утас хэрэглэгчийн эзлэх хувийг орон сууцны төрлөөр авч үзэхэд гэрт амьдардаг хүн амын 63.3 хувь, байшинд амьдардаг хүн амын 83.1 хувь гар утас хэрэглэдэг байна. Энэ нь гэр болон байшин хороололд амьдардаг хүн амын амьжиргааны төвшин ялгаатай байдагтай холбоотой юм.

ХҮСНЭГТ 3.6. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ОРОН СУУЦНЫ ТӨРЛӨӨР

| Сууцны зориулалт | Бүгд | Хот | Хөдөө |
|--------------------------------|------|------|-------|
| Бүгд | 74.0 | 83.1 | 54.5 |
| Гэр | 63.3 | 75.7 | 51.0 |
| Бусад сууц | 62.7 | 66.3 | 54.9 |
| Байшин | 83.1 | 87.3 | 62.6 |
| Орон сууцны байшин | 91.7 | 91.9 | 84.1 |
| Бие даасан тохилог сууц | 91.4 | 91.5 | 84.8 |
| Сууцны тусдаа байшин | 76.6 | 82.8 | 59.7 |
| Оюутан, сурагчдын нийтийн байр | 94.7 | 95.3 | 82.3 |
| Ажиллагчдын нийтийн байр | 83.7 | 84.7 | 82.2 |
| Нийтийн зориулалтын бусад байр | 81.8 | 82.7 | 76.9 |

3.3.2 ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ

Интернетийн хэрэглээ нь тухайн хүний амьдардаг сууцанд, ажлын газрын байрт интернетийн сүлжээ орсон эсэхээс хамааралтай байдаг. Интернетийн үйлчилгээ үзүүлэгч ISP компаниуд бага зардлаар олон өрхийг интернетийн үйлчилгээнд хамруулах зорилгоор гэр хорооллоос илүүтэйгээр байшин хороололд интернетийн сүлжээг оруулдаг. Харин 2009 оноос гар утасны үйлчилгээ үзүүлэгч оператор компаниуд 3G технологийг нэвтрүүлснээр өндөр хурдны шилэн кабель хүрч чадаагүй гэр хороолол, Улаанбаатар хотын төвөөс алслагдсан зуслангийн газарт амьдардаг хүмүүс интернетийг хэрэглэх боломж бүрдсэн юм.

Монгол Улсын нийт өрхийн суурин хүн амын 53.6 хувь байшинд амьдарч байхад интернет хэрэглэдэг хүн амын 79.2 хувь байшинд, 18.6 хувь гэрт, 2.3 хувь бусад сууцад амьдардаг байна. Зургаа, түүнээс дээш настай нийт хүн амын интернет хэрэглэглээг орон сууцны төрлөөр ангилан үзэхэд нэлээд ялгаатай байна. Тухайлбал, оюутан сурагчдын нийтийн байрт амьдрагчдын интернетийн хэрэглээ хамгийн дээгүүр, дараа нь бие даасан тохилог сууц, орон сууцны байшинд амьдрагчдын интернетийн хэрэглээ орж байна. Харин гэрт амьдардаг хүмүүсийн интернетийн хэрэглээ хамгийн доогуур буюу 13.3 хувьтай байгаа нь гэрт амьдардаг хүмүүсийн талаас илүү хувь хөдөө амьдардаг мөн интернетийн сүлжээ кабелийг гэр хороололд оруулдаггүйтэй холбон тайлбарлаж болно.

ЗУРАГ 3.19. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭЭНИЙ ТӨВШИН, ОРОН СУУЦНЫ ТӨРЛӨӨР



Интернет хэрэглэдэг хүнийг интернет хаана хэрхэн хэрэглэдгээр нь ангилан үзэхэд гэртээ байнга хэрэглэдэг 229.5 мянган хүний 94.9 хувь, шаардлагатай үед интернет хэрэглэдэг хүний 68.6 хувь байшинд амьдардаг байна. Өөрөөр хэлбэл, байшин, орон сууцанд амьдардаг хүн интернетийг түлхүү гэрээсээ хэрэглэдэг юм байна. Үүнийг мэдээж интернетийн сүлжээний хамрах хүрээтэй холбон ойлгоно.


**ХҮСНЭГТ 3.7. ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭДЭГ ХҮНИЙ ТОО, ХЭРЭГЛЭДЭГ ХЭЛБЭР, ОРОН СУУЦНЫ
ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР**

| Орон сууц, байшингийн төрөл | Интернет гэртээ байнга хэрэглэдэг | | Интернет бусад газарт байнга хэрэглэдэг | | Интернет шаардлагатай үед хэрэглэдэг | |
|--------------------------------|-----------------------------------|-------|---|-------|--------------------------------------|-------|
| | Хүний тоо | Хувь | Хүний тоо | Хувь | Хүний тоо | Хувь |
| Бүгд | 229 467 | 100.0 | 144 379 | 100.0 | 335 779 | 100.0 |
| Гэр | 8 449 | 3.7 | 27 451 | 19.0 | 95 825 | 28.5 |
| Бусад сууц | 3 140 | 1.4 | 3 547 | 2.5 | 9 536 | 2.8 |
| Байшин | 217 878 | 94.9 | 113 381 | 78.5 | 230 418 | 68.6 |
| Орон сууцны байшин | 180 313 | 78.6 | 58 090 | 40.2 | 80 463 | 24.0 |
| Бие даасан тохилог сууц | 4 658 | 2.0 | 1 687 | 1.2 | 2 279 | 0.7 |
| Сууцны тусдаа байшин | 28 231 | 12.3 | 44 682 | 30.9 | 120 446 | 35.9 |
| Оюутан, сурагчдын нийтийн байр | 1 914 | 0.8 | 3 706 | 2.6 | 13 306 | 4.0 |
| Ажиллагчдын нийтийн байр | 1 947 | 0.8 | 3 418 | 2.4 | 9 645 | 2.9 |
| Нийтийн зориулалтын бусад байр | 815 | 0.4 | 1 798 | 1.2 | 4 279 | 1.3 |



ДОРӨВЛҮГЭЭР БҮЛЭГ

ХАМААРЛЫН ШИНЖИЛГЭЭ





Өмнөх бүлгүүдэд гар утас, интернетийн хэрэглээний төвшинг тухайн хүний нас, хүйс, боловсролын төвшин, гэр бүлийн байдал, хөгжлийн бэрхшээл, хаана оршин суудаг, байршил, хөдөлмөр эрхлэх, орон сууцны төрөл зэрэг үзүүлэлтийн хувьд хэр зэрэг ялгаатай байгааг харууллаа. Харин энэ бүлэгт аймаг, нийслэлийн гар утас, интернетийн хэрэглээ нь тухайн газрын хүн ам зүйн болон нийгэм эдийн засгийн үзүүлэлтээс хэр зэрэг хамааралтай байгааг шугаман регрессийн аргаар нарийвчлан авч үзье.

4.1 ГАР УТАС ХЭРЭГЛЭХ ТӨВШИНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Гар утас хэрэглэх төвшин нь тухайн газар нутагт оршин амьдарч буй хүн амын насын бүтэц буюу хэр залуу бүтэцтэйгээс хамаарна. Мөн хүн амын боловсролын төвшин, хот суурин газарт хэдэн хувь нь амьдардаг, хүн амын ажил эрхлэлтийн төвшин нь тухайн аймгийн гар утас хэрэглэх төвшинг хэдэн хувьтай тайлбарлаж байгааг тодруулан авч үзье.

$$M = f (A, E1, E2, E3, Em, L)$$

- M— Гар утас хэрэглэх төвшин
- A— Нийт хүн амд 15-60 (залуу насын бүтцийг илэрхийлэх насын бүлэг) насын бүлгийн хүн амын эзлэх хувь
- E1— Нийт хүн амд боловсролтой (бага) хүн амын эзлэх хувийн жин
- E2— Нийт хүн амд бүрэн дунд боловсролтой хүн амын эзлэх хувийн жин
- E3— Нийт хүн амд дээд боловсрол эзэмшсэн хүн амын эзлэх хувийн жин
- Em— Нийт хүн амд хөдөлмөр эрхэлдэг хүн амын эзлэх хувь
- L— Хотын хүн амын эзлэх хувийн жин

Персоны корреляцийн коэффициентээр дээрх хүчин зүйлс хоорондын хамаарлыг тооцоход гар утас хэрэглэх төвшин, хүн амын боловсролын төвшний хоорондын хамаарал бусад хувьсагчтай харьцуулахад хамгийн өндөр $K= 0.91$ буюу хүчтэй хамааралтай гарлаа ($M^A = 0.85$, $M^E1 = 0.91$, $M^E2 = 0.90$, $M^E3 = 0.80$, $M^Em = 0.31$, $M^L = 0.70$).

Харин дээрх хүчин зүйлсийн нөлөөллийг тооцохын тулд регрессийн шинжилгээ хийхэд $R= 0.93$, детерминациийн коэффициент $R^2 = 0.87$ гарч байгаа ба F шинжүүр онолын утгаасаа их гарч байна. Тиймээс аймгийн гар утас хэрэглэх төвшинд тухайн аймгийн хүн амын залуу насын бүтэц, боловсролын төвшин, хөдөлмөр эрхлэлт, байршил гэсэн хүчин зүйлс 87.3 хувийн нөлөө үзүүлэхийг харуулна.

| Модел | Корреляцийн коэф | Детерминациийн коэф | Засварлагдсан детерминациийн коэф | Стандарт алдаа |
|-------|------------------|---------------------|-----------------------------------|----------------|
| 1 | .934(a) | .873 | .314 | 4.9703 |

4.2 ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭХ ТӨВШИНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

$$I = f (A, E1, E2, E3, Em, L, H)$$

- M— Интернет хэрэглэх төвшин
- A— Нийт хүн амд 15-60 (залуу насын бүтцийг илэрхийлэх насын бүлэг) насын бүлгийн хүн амын эзлэх хувь
- E1— Нийт хүн амд боловсролтой (бага) хүн амын эзлэх хувийн жин
- E2— Нийт хүн амд бүрэн дунд боловсролтой хүн амын эзлэх хувийн жин
- E3— Нийт хүн амд дээд боловсрол эзэмшсэн хүн амын эзлэх хувийн жин

- Ем – Нийт хүн амд хөдөлмөр эрхэлдэг хүн амын эзлэх хувь
 Л – Хотын хүн амын эзлэх хувийн жин
 Н – Байшинд амьдардаг хүн амын эзлэх хувь

Персоны корреляцийн коэффициентээр дээрх хүчин зүйлс хоорондын хамаарлыг тооцоход интернет хэрэглэх төвшин, хүн амд дээд боловсрол эзэмшсэн хүн амын эзлэх хувийн жингийн хоорондын хамаарал бусад хувьсагчтай харьцуулахад хамгийн өндөр $K=0.98$ буюу хүчтэй хамааралтай гарлаа ($I^A = 0.83$, $I^E1 = 0.86$, $I^E2 = 0.90$, $I^E3 = 0.98$, $I^Em = 0.21$, $I^L = 0.88$, $I^L = 0.55$).

Харин регрессийн шинжилгээгээр $R=0.99$, детерминацийн коэффициент $R^2=0.98$ гарч байгаа ба F шинжүүр онолын утгасаа их гарч байна. Тиймээс аймгийн интернет хэрэглэх төвшинд тухайн аймгийн хүн амын залуу насны бутэц, боловсролын төвшин, хөдөлмөр эрхлэлт, байршил, орон сууцны төрөл 97.8 хувийн нөлөө үзүүлэхийг харуулна.

| Модел | Корреляцийн коэф | Детерминацийн коэф | Засварлагдсан детерминацийн коэф | Стандарт алдаа |
|-------|------------------|--------------------|----------------------------------|----------------|
| 1 | .989(a) | .978 | .966 | 1.9375 |


4.3 ГАР УТАС, ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ХООРОНДЫН ХАМААРАЛ

Гар утас, интернетийн хэрэглээ нь тухайн хүний нас, боловсролын төвшин, байршил, хөдөлмөр эрхлэлт зэрэг хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс хэр хамааралтай болон ялгаатай байдгийг авч үзэв. Мэдээлэл, харилцаа холбооны хэрэглээ нь хүн амын нягтрал, эдийн засгийн төвлөрөл ихтэй болон төв зам дагуу газарт оруулсан мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний хамрах хүрээнээс ихээхэн хамааралтай байдаг болох нь ажиглагдаж байна. Эдгээр бүх хүчин зүйлсийн нөлөөгөөр аймаг, нийслэлийн гар утас, интернетийн хэрэглээ тодорхойлогдож буй хэмээн ойлгож болно. Тэгвэл гар утас, интернетийн хэрэглээ нь хоорондоо хэрхэн хамааралтай болохыг шугаман регрессийн аргаар нарийвчлан авч үзье.

$$Y = f(X)$$

Y – Интернет хэрэглэх төвшин

X – Гар утас хэрэглэх төвшин





| Модел | Корреляцийн коэф | Детерминацийн коэф | Засварлагдсан детерминацийн коэф | Стандарт алдаа |
|-------|------------------|--------------------|----------------------------------|----------------|
| 1 | 0.86 | 0.74 | 0.73 | 6.13 |

Корреляцийн коэффициент харьцангуй өндөр гарч байгаа нь гар утас, интернетийн хэрэглээ хоорондоо хүчтэй хамааралтайг харуулна. Харин детерминацийн коэффициент 0.74 байгаа нь гар утасны хэрэглээ нь интернетийн хэрэглээнд 74 хувийн нөлөөтэй байгааг харуулах ба F шинжүүр онолын утгаасаа их ($F = 57.708$, $F_{\text{signif}} = 2.568$) гарч байна.

Тэгшитгэл:

$$Y = 48.5 + 0.963X$$

Дээрх тэгшитгэл нь гар утасны хэрэглээ 1 нэгжээр нэмэгдэхэд интернетийн хэрэглээ 0.96 нэгжээр нэмэгдэхийг харуулж байна.

Эндээс үзэхэд тухайн газрын гар утасны хэрэглээ хэдий чинээ өндөр байна тэдий чинээ интернетийн хэрэглээ өндөр байна гэсэн үг юм. Учир нь мэдээлэл, харилцаа холбооны энгийн хэрэглээ болох гар утсыг хэрэглэснээр тухайн хүний бусад төрлийн орчин үеийн техник технологийг хэрэглэх чадамж, хэрэгцээ шаардлага нь нэмэгддэгтэй холбоотой юм.

ДУГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ





ДҮГНЭЛТ

“Гар утас, интернет хэрэглэгч: тоо, бүтэц” сэдэвчилсэн судалгаа нь Монгол Улсын хувьд энэ төрлийн анхных бөгөөд улсын хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны хэрэглээний төвшинг тооцоходо олон улсын ойлголт, тодорхойлолт, аргачлалыг ашиглаг. Манай улсад гар утас, интернетийн үйлчилгээний суурь тавигдсанаас хойш 15 жилийн хугацаа өнгөрсөн ч 2010 оны байдлаар суурин хүн амын 74.0 хувь гар утас, 30.6 хувь интернет хэрэглэдэг болжээ. Мянганы хөгжлийн цогц бодлого, “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр зэрэг хууль тогтоомжийн бусад актад хүн амын гар утас, интернетийн хэрэглээг дэмжсэн бодлого хөтөлбөрийг тусгаж, түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалттай арга хэмжээ авсны үндсэн дээр хэрэглээний төвшин дэлхийн болон Азийн орны төвшинтэй зэрэгцэж, зарим үзүүлэлтээр түрүүлж байгааг энэхүү судалгаа харуулав.

2021 онд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 95 хүртэл хувьд суурин болон хөдөлгөөнт хэлбэрээр мэдээлэл, харилцааны технологийн үйлчилгээг хүн бүр хүртэх боломжийг бүрдүүлэх зорилт тавьсан. 2010 оны байдлаар 6, түүнээс дээш наасны суурин хүн амын дөрөвний нэг нь гар утас, интернетийг огт хэрэглэхгүй байна. Дээрх зорилтод хүрэхийн тулд өнөөгийн төвшинг сайжруулах ѿ шаттай алхмыг хийх хэрэгтэйг харуулж байгаа билээ.

Гар утсыг 15-60 наасны хүмүүс түлхүү хэрэглэж байхад интернетийг залуучууд их хэрэглэж байлаа. Ялангуяа улс орныхоо ирээдүйн хөгжилд гар бие оролцох оюутан, сурагчдын гар утас, интернет хэрэглэх төвшин өндөр байгаа нь сайн хэрэг юм. Энэ нь 2005 оноос хэрэгжсэн “Цахим боловсрол” хөтөлбөрийн хүрээнд тэдний мэдээллийн технологийн хэрэглээний мэдлэг, дадал сайжирсантай холбоотой.

Интернет хэрэглэдэг хүн амын бараг тал хувь нь шаардлагатай ѿед интернет хэрэглэдэг гэж хариулсан байна. Эндээс байнгын бус, шаардлагатай ѿедээ интернет кафе, эсвэл төрөл садан, найз нөхдийнхөө гэр болон ажлын газарт хэрэглэдэг хүний эзлэх хувь дээгүүр байгааг харуулна.

Гар утас, интернет хэрэглэх нь хот, хөдөөд ялгаатай байна. Аймгийн хүмүүсийн хэрэглэх төвшин бас зөрүүтэй байв. Үүний шалтгааныг хөдөө орон нутагт мэдээлэл харилцаа холбооны дэд бүтэц харьцангуй тааруу хөгжсөнтэй холbon ойлгож болно. Бас хөдөө, орон нутагт амьдардаг хүмүүсийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, тэдний гар утас, интернет хэрэглэх шаардлага хэрэгцээ бүрдсэн эсэх болон хэрэглэх зан төлөвтэй холбоотой билээ. Хөдөө, орон нутагт амьдардаг малчдын гар утас хэрэглэх төвшин доогуур байгаа нь Монгол Улсын Засгийн Газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтыг хэрэгжүүлэхэд илүү анхаарах хэрэгтэйг харуулна.

Аливаа улсын хүн амын боловсролын төвшин нь тухайн улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг тодорхойлогч нэг гол үзүүлэлт мөн. Үүний нэгэн адилаар аймаг, нийслэлд амьдардаг хүмүүсийн гар утас, интернет хэрэглэх нь хүн амын боловсролын төвшингөөс хамааралтай байгааг шинжилгээ харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний гар утас, интернет хэрэглэх нь хэвийн хүн амын хэрэглээнээс 20 орчим пунктээр доогуур байна. Ялангуяа төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэглээ доогуур байна.

Үүнээс гадна өрхийн гар утас, интернет хэрэглэх төвшинг тодорхойлохыг зорив. Учир нь олон улсын хэмжээнд мэдээллийн технологийн хөгжлийн хүрсэн хэмжээг дан ганц хүн амын хэрэглээний төвшин төдийгүй өрхийн хэрэглээг чухалчлан авч үздэг. Нийт өрхийн 10 орчим хувьд гар утас хэрэглэдэг хүнгүй байна. Ийм өрхийн 75 хувь нь хөдөө амьдардаг. Хүн амын нягтрал багатай хөдөө нутагт гар утасны үйлчилгээ үзүүлэгч оператор компанийн сүлжээ бүрэн хүрч чадаагүйтэй холбоотой билээ. Нэг, түүнээс дээш хүн нь гэртээ интернет хэрэглэдэг өрхийн тоогоор интернет холболттой өрхийн тоог гаргасан. Нийт өрхөд гэртээ

интернеттэй өрхийн эзлэх хувь 12.3 (хотод 17.9, хөдөөд 0.7 хувь) байгаа нь Азийн орны төвшингөөс доогуур байна.

ISP компаниуд мэдээж бага зардлаар олон хэрэглэгч татах зорилгын хүрээнд орон сууцны хороололд өндөр хурдны интернетийн сүлжээг оруулдаг нь мэдээж. Манай улсад хүн амын бараг тал хувь нь гэрт амьдардаг. Тэдний 13.3 хувь нь интернетийг ямар нэгэн байдлаар хэрэглэж байна. Энэ бол муу үзүүлэлт. Энэхүү ялгаатай байдлыг арилгах зарим нэг үр дүнтэй арга хэмжээг авах нь зүйн хэрэг билээ.



ЗӨВЛӨМЖ

Гар утас, интернет хэрэглэх хот, хөдөөгийн ялгаатай байдлыг ойртуулах, арилгах асуудлыг анхаарч зохих арга хэмжээг авах нь зүйтэй юм. Үүний тулд гар утасны болон интернетийн сүлжээний давхардлыг арилгаж байршилаас үл хамааран хүн бүр мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүртэх боломжийг сайжруулах нь чухал юм. Орон нутагт гар утасны дэвшилтэй 3G технологийн сүлжээг оруулах бодлого баримталснаар тухайн нутгийн хүн амын интернет хэрэглэх явдлыг дэмжих боломжтой.

Монгол Улсын Үндсэн хуульд хүн бүрийн тэгш эрхийг баталгаажуулсан. Үүнийг хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэн бусдын адил гар утас, интернетийг өдөр тутмынхаа амьдралд хэрэглэх нь зүй ёсны асуудал билээ. Тиймээс эдгээр хүмүүсийн хэрэглээг нэмэгдүүлэх тал дээр төрийн захирагааны холбогдох төв байгууллагаас бодлого хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Дараагийн тооллогоор хүн амаас гар утас, интернет хэрэглэдэг эсэх мэдээллийг авахдаа:

- Цаг хугацааны хязгаарлалт тавих;
- Сүлжээний хамрах хүрээнээс гадуурх хүн амын хэрэглээг лавшуулах замаар үнэн зөв мэдээлэл цуглуулахыг хичээх нь зөв.

Гар утас, интернет хэрэглэгчийг тодорхойлохдоо ХХЗХ-оос гаргасан мэдээлэлд үндэслэх учиртай. Гэтэл энэхүү мэдээлэл нь улсын хэмжээнд явуулсан тооллогын мэдээллээс нэлээд зөрүүтэй байгаа нь МХХТ-ын салбарын цаашдын бодлого, хөтөлбөрийг боловсруулахад үнэн зөв, бодитой мэдээлэл хэрэгтэй байгааг харуулна. Үүний тулд гар утас, интернетийн үйлчилгээ үзүүлэгч компаниас ирүүлсэн мэдээллийг тулгаж шалгасны үндсэн дээр тухайн мэдээллийг нийтэд түгээх, төр, засгийн бодлого боловсруулахад хэрэглэх, цаашилбал, богино хугацааны давтамжтайгаар үнэн зөв мэдээлэл гаргадаг тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хүн амын гар утас, интернет хэрэглээг цаашид гүнзгийрүүлэн судалж энэ талаар төр, засгаас баримтлах бодлого, хөтөлбөрт харилцаа холбооны илүү дэлгэрэнгүй мэдээллийг цаг алдалгүй оруулах шаардлагатай байна. Улмаар өнөөгийн төвшинг сайжруулах томоохон зорилтыг дэвшүүлж түүнийг хэрэгжүүлэх олон нийтэд тогтмол мэдээлж байх нь зүйтэй юм.

ХАВСРАЛТ





Хүмүүнчлэг төр зэрээм, Төрд хүмүүнчлэг зэрээм

**ХАВСРАЛТ 1. ГАР УТАС, ИНТЕРНЕТ, ХОЁУЛАНГ НЬ ХЭРЭГЛЭДЭГ ХҮН АМЫН ТОО,
АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХҮЙСЭЭР**

| Аймаг, нийслэл | Гар утас хэрэглэдэг | | | Интернет хэрэглэдэг | | | Гар утас, интернетийг хослуулан хэрэглэдэг | | |
|-------------------|---------------------|----------------|----------------|---------------------|----------------|----------------|---|----------------|----------------|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| БҮГД | 1 714 645 | 826 860 | 887 785 | 709 625 | 325 334 | 384 291 | 685 278 | 310 701 | 374 577 |
| Архангай | 38 757 | 18 735 | 20 022 | 7 056 | 2 614 | 4 442 | 6 689 | 2 407 | 4 282 |
| Баян-Өлгий | 27 113 | 14 704 | 12 409 | 5 695 | 2 759 | 2 936 | 5 280 | 2 558 | 2 722 |
| Баянхонгор | 39 811 | 19 374 | 20 437 | 6 438 | 2 725 | 3 713 | 6 120 | 2 548 | 3 572 |
| Булган | 29 006 | 14 482 | 14 524 | 5 525 | 2 459 | 3 066 | 5 125 | 2 219 | 2 906 |
| Говь-Алтай | 29 219 | 14 741 | 14 478 | 5 776 | 2 467 | 3 309 | 5 539 | 2 333 | 3 206 |
| Дорнговь | 37 319 | 17 945 | 19 374 | 11 760 | 5 175 | 6 585 | 11 213 | 4 823 | 6 390 |
